



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Салдангийн ОДОНТУЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-08-90, Факс: 32-70-16
E-mail: odontuyas@parliament.mn
http://www.parliament.mn

2022.03.23 № УИХ-03/2572

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.ОДОНТУЯА
Б.БАЯРСАЙХАН
Ц.ДАВААСҮРЭН
Т.ДОРЖХАНД
Б.ЖАРГАЛМАА
М.ОЮУНЧИМЭГ
Д.ӨНӨРБОЛОР
Б.ПҮРЭВДОРЖ
Д.САРАНГЭРЭЛ
Б.САРАНЧИМЭГ
Ж.ЧИНБҮРЭН

00000000



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Салдангийн ОДОНТУЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-08-90, Факс: 32-70-16
E-mail: odontuyas@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.02.14 № УИХ-03/1275
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсаныг хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт ~~67~~ хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.ОДОНТУЯА

0000005



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20^{дд} он ⁰¹ дугаар
сарын ²⁰-ны өдөр

Дугаар ... ¹⁰⁰¹/₁₁₇

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.ОДОНТУЯА
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225001032

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлд:

“ҮИИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1. Хуулийн төслийн танилцуулгад чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй амтат ус, ундаа зэрэг бүтээгдэхүүн нь сургуулийн сурагчдын илүүдэл жин, таргалалт үүсгэх хүчин зүйл болж байгаа талаар, түүнчлэн дээрх төрлийн бүтээгдэхүүн нь хүн амын таргалалт, илүүдэл жин үүсэх суурь нөхцөл болж, эрүүл мэндэд хор уршиг учруулж байгаа талаар дурджээ.

Эдгээр сөрөг үр дагаврын талаар холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт, тоон болон бусад баримт мэдээлэл, судалгаа нь хуулийн төслийн танилцуулга, хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан судалгаанд тусгагдаагүй байгааг анхаарах нь зүйтэй бөгөөд дээрх төрлийн бүтээгдэхүүнд татвар ногдуулснаар нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгааг хийлгэх шаардлагатай;

2. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараахь эдийн засгийн сэргэлтийн арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа энэ цаг үед дээрх хуулийн төсөл нь дотоодын үйлдвэрлэгч, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд татварын дарамт, зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж болзошгүй байна;

3. Түүнчлэн, дотоодын үйлдвэрлэлийн болон импортоор оруулж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага болон тэдгээрт тавих хяналтын талаар холбогдох хуульд дараахь байдлаар зохицуулсан байна:

3.1. Эрүүл ахуйн тухай хуулийн 8.2-т хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулахаар;


3.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.1-д хяналтын байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг

удирдах, 15.3-т лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори ажиллахаар заасан бөгөөд мөн зүйлийн 15.2.1-д зааснаар тус лаборатори нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд тандалт судалгаа, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагад тухай бүрт хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна;

3.3. эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хор уршиг учруулж болзошгүй хүнсний бүтээгдэхүүн зориуд худалдсан, импортлоход холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулаагүй үйлдэлд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд зааснаар оногдуулах хариуцлагыг тус тус хуульчилсан байна.


Иймд сургуулийн орчинд зарагдаж байгаа чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй амтат ус, ундаа зэрэг бүтээгдэхүүнийг худалдаалах, дотооддоо үйлдвэрлэх, импортоор оруулж ирэх болон түүнтэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг татвар ногдуулах замаар бус харин дээр дурдсан хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласны үндсэн дээр асуудлыг зохицуулах боломжтой гэж үзэж байна;

4. Хуулийн төслийн зүйл, заалтын агуулга болон хууль зүйн техник, найруулгыг дахин нягталж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулга, хэл зүй, найруулгад тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



С.ОДОНТУЯА

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй хэмээн тунхагласан.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А/369 тоот тушаалаар батлагдсан “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 тоот тушаалд “Тусгай дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага”-ыг мөрдөж ажиллах хэмээн заасан байна.

Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан, таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20 хувийн татвар ногдуулахыг уриалсныг үндэслэн Онцгой албан татварын тухай хуулийн төсөл боловсруулахаар холбогдох судалгааг хийсэн.

1.2. Практик шаардлага

Монгол улсын хэмээнд ерөнхий боловсролын сургуулийн 2100 гаруй сурагчдын амтат ус, ундааны хэрэглээ, тэдний таргалалтыг судалж үзэхэд 14 хувь нь илүүдэл жин, таргалалттай, өдөрт ууж буй шингэний 1/3-2/3 нь амтат ус, ундаа, цай эзэлж байна. Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс, Хоол тэжээлийн талаар хийсэн үндэсний судалгаанаас харахад 7-11 настай хүүхдийн таргалалт, илүүдэл жин 2010 онд 4 хувь байсан бол 2017 онд 28 хувь болж 7 дахин нэмэгдсэн байна. Энэ судалгаагаар 15-49 насны эрчүүд, эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь илүүдэл жин, таргалалттай гэж гарсан байна.

Хэдийгээр зарим сургуулийн цайны газар, буфетэнд амтат ус, ундаа зардаггүй ч сурагчид хэдхэн алхмын цаадах дэлгүүрээс худалдан авч байна. “Нас нь нэмэгдэх тусам хүүхдүүд сургуулийн ойр орчмоос амтат ус, ундаа авах нь ихэсдэг. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын судалгаанаас харвал 14-18 насныхны 54.9 хувь нь сургуулийн ойр орчмоос амтат ус, ундаа худалдаж авдаг гэж хариулжээ.

Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн Үндэсний хөтөлбөр батлах тухай 289 дүгээр тогтоолын хавсралтын 1.1, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25 хувь, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг 10 хувь, давс, тамхины хэрэглээг 30 хувь, цусны даралт ихсэлтийг 25 хувь, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барих”-аар, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.2.2-ын 3 дахь зорилтод “2016-2020 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүнд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4 хувиар, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл хувиар бууруулах”-аар дэвшүүлсэн. Түүнчлэн 3.1.8-д “архи, тамхи, чихэрлэг хүнс зэрэг хүний эрүүл мэндэд эрсдэл учруулдаг хэрэглээг үнэ, татварын бодлогоор дамжуулан бууруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах замаар шийдвэрлэх” хэмээн тусгасан байдаг.

Эрүүл мэндийн яамны мэдээллээр халдварт бус өвчний өвчлөлөөр зүрх судасны өвчин хоёрдугаарт ордог байна. Зүрх судасны эмгэгээс хамгийн их тохиолдох нь артерийн судасны хатуурал бөгөөд энэ эмгэгийн суурин дээр артерийн даралт ихсэх, зүрхний шигдээс, тархины цус харвалт зэрэг нас баралтаар тэргүүлдэг эмгэгүүд хүндрэл хэлбэрээр илэрдэг. Манай улсад артерийн даралт ихсэх өвчин насанд хүрсэн дөрвөн хүн тутмын гуравт тохиолдож байгаа нь маш их сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байгаа. Мөн зүрхний титэм судасны өөрчлөлтөөс болж зүрхний булчинд цусан хангамж дутагдаж зүрхний бах, зүрхний шигдээс өвчнөөр өвчлөх, нас барах явдал их байна. Зүрх судасны эмгэг нь хүний амьдралын буруу хэв маягаас үүсдэг. Зүрх судасны эмгэг үүсэхэд нас, хүйс, удамшил нөлөөлөхөөс гадна хоол хүнсний буруу хэрэглээ ялангуяа өөх тос, нүүрс ус, давс ихтэй хоол хэтрүүлэн хэрэглэх зэрэг амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй. Хөдөлгөөний хомсдол, таргалалт, стресс, чихрийн шижин ч мөн зүрх судасны эмгэг үүсэх хүчин зүйлүүд болдог байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор амтат ус, ундаанд хамгийн багадаа 20%-ийн татвар ногдуулахыг уриалсан зөвлөмжийн дагуу импортын болон дотоодын үйлдвэрийн амтат ус, ундаанд онцгой албан татвар ногдуулах зорилготой.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас амтат ус, ундаанд онцгой албан татвар ногдуулах замаар илүүдэл жин, таргалалттай үр дүнтэйгээр тэмцэхийг зөвлөмж болгосны дагуу АНУ-ын 8 муж, Австрали, Мексик, Чили, Дани, Финлянд, Норвеги, Франц, Их Британи, Ирланд, Номхон далайн арлын орнууд, БНСУ, Камбож, Өмнөд Африк зэрэг дэлхийн 40 гаруй улсад амтат ус, ундаанд онцгой албан татвар ногдуулаад байна.

Хуулийн төсөл нь 4 зүйлтэй байхаар боловсруулагдах бөгөөд төсөлд амтат ус, ундаа болон түүнтэй адилхан импортын болон эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдэд онцгой албан татвар ногдуулахаар заасан болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар

Монгол улсын хэмжээнд амтат ус, ундааны үйлдвэрлэл болон импортонд 20 хувийн онцгой албан татвар тогтоосны үр дүнд жилд нэг хүнд ногдох чихэрлэг ундааны хэрэглээг 22.8 литрээр бууруулах боломжтой тооцоолол гарч байна. Онцгой албан татвар ногдуулахын цаад мөн чанар нь үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрлэж буй ундааны сахарыг багасгах, гаднаас оруулж ирэх хувийг бууруулах, харин түүнийг орлуулах цэвэр ус, эрүүл хүнс, жимс, ногооны хэрэглээг дэмжих, нөгөө талаар хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, сургуулийн орчинд эрүүл хүнс, ус, ундаа борлуулах зэрэгт чиглэсэн боловсролын интервенцийг дэмжихэд чиглэдэг байна. Тэрнээс биш татварын орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг шууд хязгаарлах гэдэг талаас харах нь өрөөсгөл бөгөөд ямар ч бодлого, шийдвэрийг зөв хэрэгжүүлэх, түүнд тавих хяналт их чухал.

Манай улсад 2012-2017 оны хооронд амтат ус, ундааны үйлдвэрлэл 30 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд жимсний шүүстэй харьцуулахад хийжүүлсэн ундааны үйлдвэрлэл эрс өссөн байна. Мөн Монгол Улсын 2012 оны өрхийн чихэрлэг ундааны зардлыг 2015 оныхтой хурьцуулахад 41 хувиар өссөн нь тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хэрэглэгчийн эрүүл мэнд ноцтой үр дагаварт хүрэхийг сэрэмжлүүлж байгаа баримт юм. Өвчилсөн үеийн оношилгоо, эмчилгээ, даатгал, нөхөн сэргээх зардал нь асар их бөгөөд харин сэргийлэх, хамгаалах, хянахад чиглэсэн, цаг үеэ зөв олсон шийдэл, шийдвэр нь зардал бага, үр дүн нь их байна.

Хуулийн төсөл батлагдсанаар онцгой албан татвар ногдуулах бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, улсын төсвийн орлого нэмэгдэх, нэмэгдсэн орлогоос хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой, мөн эрүүл, органик бүтээгдэхүүн хэрэглэх орчин нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, Монгол Улсын, олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлд, доор дурдсан агуулгатай 4.1.5 дахь хэсэг нэмсүгэй:

“4.1.5. Чихрийн агууламж орсон хийжүүлсэн болон хийжүүлээгүй амтат ус, ундаа”

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.1 дэх хэсэг нэмсүгэй:

“5.1.Энэ хуулийн 4.1-д заасан бараанд онцгой албан татвар ногдуулахдаа дараах биет нэгжийг үндэслэл болгоно.”

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татвар ногдуулах биет нэгж
6	Чихрийн агууламж орсон амтат ус, ундаа	1л

3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1 дэх хэсэг нэмсүгэй:

“6.1.Энэ хуулийн 4.1.1-т заасан Чихрийн агууламж орсон амтат ус, ундаанд тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна.”

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ноогдуулах онцгой албан татварын хэмжээ			
			2024онд	2025онд	2026онд	
10	Чихрийн агууламж орсон амтат ус, ундаа	1 л	100мл-т агуулагдах чихэр 0-5гр	0	0	0
		1 л	100мл-т агуулагдах чихэр 5гр-с дээш	500 төгрөг	525 төгрөг	550 төгрөг

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

“Онцгой албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн
төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй хэмээн тунхагласан.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А/369 тоот тушаалаар батлагдсан “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 207 тоот тушаалд “Тусгай дэглэмтэй хүн, нярай, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд тавих шаардлага”-ыг мөрдөж ажиллах хэмээн заасан.

Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан, таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20 хувийн татвар ноогдуулахыг уриалсан.

Монгол Улсын дунд сургуулийн 2100 гаруй сурагчдын дунд чихэрлэг ундааны хэрэглээ, тэдний таргалалтыг судалсан судалгаанаас үзэхэд 14 хувь нь илүүдэл жин, таргалалттай, өдөрт ууж буй шингэний 1/3-2/3 нь чихэртэй ундаа, ус, цай эзэлж байна. НЭМҮТ –ээс хийсэн Хоол тэжээлийн үндэсний судалгаанаас харахад 7-11 настай хүүхдийн таргалалт, илүүдэл жин 2010 онд 4 хувь байсан бол 2017 онд 28 хувь болж 7 дахин нэмэгдсэн байна. Энэ судалгаагаар 15-49 насны эрчүүд, эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь илүүдэл жин, таргалалттай байгаа нь үнэхээр санаа зовоосон асуудал болж байна. Мөн хүүхдүүдийн дунд эрүүл шүдтэй хүүхэд ховордсон нь мөн л чихэрлэг бүтээгдэхүүнүүдтэй холбоотой. Тэгэхээр өвчилсөн, хорхойтсон шүд, эмгэгшсэн эрхтэнтэй зууралдах бус түүний шалтгаан болж буй хүчин зүйл, эрсдлийг бууруулах нь хамгийн зөв шийдэл болно.

Илүүдэл жин, таргалалтанд хүргэдэг олон хүчин зүйлийн нэг нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, тэр дундаа чихэрлэг хүнс, ундааны хэрэглээ юм. Сургуулийн орчинд зарагдаж буй шингэний дийлэнх нь чихэртэй, хийжүүлсэн ундаа, шүүс мөн чихэр, жигнэмэг, шоколад байдгийг бид мэднэ. Судалгаанд хамруулсан сурагчдын хувьд ялангуяа тарган, илүүдэл жинтэй хүүхдүүдийн ууж буй шингэний дийлэнх нь чихэрлэг ундаа, мөн чихэр, жигнэмэгийн хэрэглээ хэвийн жинтэй хүүхэдтэй харьцуулахад 2-5 дахин их байсан. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль (НЭМС)-ийн багш нарын судалгаанаас харвал 14-18 насныхны 54.9 хувь нь сургуулийн орчмоос чихэртэй ундаа худалдаж авдаг гэж хариулжээ.

Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолын хавсралтын 1.1, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод “Халдварт бус

өвчин(цаашид“ХБӨ” гэх)-өөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар ХБӨ-өөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25 хувь, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг 10 хувь, давс, тамхины хэрэглээг 30 хувь, цусны даралт ихсэлтийг 25 хувь, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барих”-аар, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-ын 3 дахь зорилтод “2016-2020 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүнд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4 хувь, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл хувиар бууруулах”-аар дэвшүүлсэн.

Бид чихэрлэг ундааны онцгой албан татварыг 10, 20, 30 хувиар нэмэхээр тооцож үзсэн. Чихэрлэг ундаанд онцгой татвар ногдуулах нь бүтээгдэхүүний үнийг өсгөж, татварын орлогыг бодитоор нэмэгдүүлнэ. Бидний тооцооллоор чихэрлэг ундаа үнийн мэдрэмжтэй бүтээгдэхүүн болох нь тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл, үнийн мэдрэмж -0.68 байгаа нь энэ төрлийн ундааны үнийн өөрчлөлтөнд хэрэглэгчдийн худалдан авалт буурах ба үр дүнд нь чихэрлэг ундаанаас хоногт авах илчлэгийн хэмжээ буурч, эрүүл хооллолтыг дэмжих ач холбогдолтой байгаа учир чихэрлэг ундаанд татварын бодлого хэрэгжүүлэх нь тохиромжтой байна. Тухайлбал 20%-ийн онцгой татвар ногдуулахад л татварын орлого зөвхөн нэг жилд 98.4 тэрбум төгрөг байх ба улсын төсвийг мөн хэмжээний төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой. 20 хувийн онцгой татвар тогтоосны үр дүнд жилд нэг хүнд ногдох чихэрлэг ундааны хэрэглээг 22.8 литрээр бууруулах боломжтой тооцоолол гарч байна. Онцгой албан татвар ногдуулахын цаад мөн чанар нь үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрлэж буй ундааны сахарыг багасгах, гаднаас оруулж ирэх хувийг бууруулах, харин түүнийг орлуулах эрүүл хүнс жимс, ногооны хэрэглээг дэмжих, нөгөө талаар хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, сургуулийн орчинд эрүүл хүнс ундаа борлуулах зэрэгт чиглэсэн боловсролын интервенцийг дэмжихэд чиглэдэг байна. Тэрнээс биш татварын орлогыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг шууд хязгаарлах гэдэг талаас харах нь өрөөсгөл бөгөөд ямар ч бодлого, шийдвэрийг зөв хэрэгжүүлэх, түүнд тавих хяналт их чухал.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН СУДАЛГААНЫ
ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ**

Улаанбаатар хот, 2021 он

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

НЭГ.	Ерөнхий мэдээлэл
ХОЁР.	Асуудлын дүн шинжилгээ
ГУРАВ.	Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал
ДӨРӨВ. хийсэн	Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг болон сөрөг тал дээр харьцуулалт
ТАВ.	Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал
ЗУРГАА.	Олон улсын эрх зүйн орчинг судалсан байдал
ДОЛОО.	Зөвлөмж

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй хэмээн тунхагласан.


Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан, таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20 хувийн татвар ноогдуулахыг уриалсан. Илүүдэл жин, таргалалтанд хүргэдэг олон хүчин зүйлийн нэг нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, тэр дундаа чихэрлэг хүнс, ундааны хэрэглээ юм. Сургуулийн орчинд зарагдаж буй шингэний дийлэнх нь чихэртэй, хийжүүлсэн ундаа, шүүс мөн чихэр, жигнэмэг, шоколад байдгийг бид мэднэ. Судалгаанд хамруулсан сурагчдын хувьд ялангуяа тарган, илүүдэл жинтэй хүүхдүүдийн ууж буй шингэний дийлэнх нь амтат ундаа, мөн чихэр, жигнэмэгийн хэрэглээ хэвийн жинтэй хүүхэдтэй харьцуулахад 2-5 дахин их байсан.

Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын дунд сургуулийн 2100 гаруй сурагчдын дунд чихэрлэг ундааны хэрэглээ, тэдний таргалалтыг судалсан судалгаанаас үзэхэд 14 хувь нь илүүдэл жин, таргалалттай, өдөрт ууж буй шингэний 1/3-2/3 нь чихэртэй ундаа, ус, цай эзэлж байна. Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвөөс хийсэн Хоол тэжээлийн үндэсний судалгаанаас харахад 7-11 настай хүүхдийн таргалалт, илүүдэл жин 2010 онд 4 хувь байсан бол 2017 онд 28 хувь болж 7 дахин нэмэгдсэн байна. Энэ судалгаагаар 15-49 насны эрчүүд, эмэгтэйчүүдийн 60 гаруй хувь нь илүүдэл жин, таргалалттай байгаа нь үнэхээр санаа зовоосон асуудал болж байна. Мөн хүүхдүүдийн дунд эрүүл шүдтэй хүүхэд ховордсон нь мөн л чихэрлэг бүтээгдэхүүнүүдтэй холбоотой. Тэгэхээр өвчилсөн, хорхойтсон шүд, эмгэгшсэн эрхтэнтэй зууралдах бус түүний шалтгаан болж буй хүчин зүйл, эрсдлийг бууруулах нь хамгийн зөв шийдэл болно.

Улаанбаатар хотын 2-18 настай хүүхэд, өсвөр үеийг хамруулан 2015, 2017 онд хийгдсэн (Undram M, Tseden P, Chimedsuren O. Water and beverage consumption in children and adolescents. [PhD thesis]. In press 2017/ судалгаанд нийгэм, эдийн засгийн мэдээлэл, хүүхдүүдийн өндөр, биеийн жин, амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөний идэвхтэй болон идэвхгүй байдал зэрэг мэдээллийг шингэний хэрэглээний 24 цагийн эргэн санах асуумжтай хослуулан цуглуулсан байна. Энэхүү судалгааны дескриптив үр дүн нь судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн гуравны нэг нь чихэрлэг ундааг сүүлийн 24 цагийн хугацаанд уусан байлаа. Хоногт хэрэглэсэн чихэрлэг ундааны хэмжээ судалгаанд хамрагдсан 2-3 настай хүүхдүүдэд 326 мл, 4-8 настай хүүхдүүдэд 414 мл, 9-13 настай хүүхдүүдэд 428 мл, 14-18 настай хүүхдүүдэд 425 мл байлаа. Хүүхэд, өсвөр үеийн чихэрлэг ундааны хэрэглээ хоногт 1 лааз (330 мл) буюу түүнээс их байгаа нь эрүүл мэндийн хувьд өндөр эрсдэлтэй юм. Цаашилбал, судалгааны хүн амд чихэрлэг ундаа нь хоногийн нийт шингэний хэрэглээний 11.0%-16.4% -ийг эзэлж байна.

Монгол улсын хэмжээнд сахар чихрийн зүйлийн хэрэглээг авч үзвэл маш ноцтой тоо гарч байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар жишсэн нэг хүний сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь хоногт 33 гр (128 ккал) буюу жилийн 12 кг байна гэж баталсан.

2020 оны байдлаар нийт хүн амын сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь 31.7 мянган тонн байсан бол нийт үйлдвэрлэл /сахар, чихрийн зүйлийн хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг энэ бүлэгт шилжүүлж тооцсон (ёотон-1.0, хатуу чихэр-0.96, шоколад, зөөлөн чихэр, зефир-0.46, жимсний чанамал, сироп-0.46, хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа-0.47)/ нь 192.6 мянган тонн байна. Нийт үйлдвэрлэлийг хэрэгцээнд харьцуулан хангамжийн түвшинг тооцоход сахар чихрийн зүйлийн хангамж 6 дахин их байна.



Зураг 1. Сахар, чихрийн зүйлийн хэрэглээ, хэрэгцээ, хангамжийн түвшин

Сахар, чихрийн зүйлийн бүлгийн хэрэглээг задлан харахад хийжүүлсэн болон хийжүүлээгүй ундаа 65.5 хувийг, сахар, ёотон 29.3 хувийг, хатуу чихэр 2.5 хувийг бусад чихрийн бүтээгдэхүүн 2.7 хувийг эзэлж байна.

Зураг 2. САХАР, ЧИХРИЙН ЗҮЙЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ, мянган тонн, сахар чихрийн зүйлд шилжүүлснээр, 2020 он



Дээрх мэдээллийг албан ёсоор Үндэсний статистикийн хорооноос авсан болно

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын судалгаанаас харвал 14-18 насныхны 54.9 хувь нь сургуулийн орчмоос чихэртэй ундаа худалдаж авдаг гэж хариулжээ.

Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолын хавсралтын 1.1., Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25 хувь, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг 10 хувь, давс, тамхины хэрэглээг 30 хувь, цусны даралт ихсэлтийг 25 хувь, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барих”-аар, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-ын 3 дахь зорилтод “2016-2020 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүнд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4 хувь, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хувь хүртэл бууруулах”-аар дэвшүүлсэн. Тэгвэл дээрх зорилтуудыг хэрэгжүүлж, ард иргэд, хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалахад амтат ус ундааны татварыг нэмэгдүүлэх нь хамгийн зардал багатай, үр дүнтэй арга юм. Амтат ундаанд 20 хувийн онцгой татвар ногдуулсны үр дүнд жилд нэг хүнд ногдох амтлаг ундааны хэрэглээг 22.8 литрээр бууруулах боломжтой тооцоолол гарч байна. Онцгой албан татвар ногдуулахын цаад мөн чанар нь татварын орлогыг нэмэгдүүлэх, эрүүл хэрэглээг хэвшүүлэх, зүрх судасны өвчин болон таргалалт, чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх, мөн дээрх өвчнөөс шалтгаалсан эрүүл мэндийн салбарт ирж буй ачааллыг бууруулах чухал зорилгуудыг агуулж байна.

ХОЁР. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2.1 Асуудлын мөн чанар, цар хүрээ

Монгол улсад 1999 онд хийсэн чихрийн шижингийн тархалтын судалгаагаар 35-аас дээш насны хүн амын дунд чихрийн шижингийн тархалт 3.1% глюкозын тэсвэржилт алдагдал 9.2% байсан байна. Тэгвэл олон улсын чихрийн шижингийн холбооны тооцоолсноор Монгол Улсад 2019 оны байдлаар 20-79 насны 1000 хүнд 99.3 буюу тухайн насны нийт хүн амыг 5% нь чихрийн шижингээр өвчлөх, чихрийн шижинтэй хүмүүсээс жилд 1330 хүн нас барсан байх магадлалтайг тогтоосон байна. Мөн чихрийн шижинтэй 20-79 насны 1000 хүнд 71.3 чихрийн шижингийн оношлогдоогүй тохиолдол ноогдож байна. Амтат ус ундаа нь таргалалт, жингийн илүүдэл үүсэх гол шалтгаануудын нэг юм. Монгол улсын нийт бүс нутгийн түвшинд илүүдэл жин ба таргалалтын тархалт насанд хүрэгчид, ялангуяа хүүхдийн дунд гамшгийн хэмжээнд хүртэл нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд тулгарч болзошгүй хамгийн том эрсдэл болсон тухай “Хоол тэжээлийн үндсний V дугаар судалгаа”-нд онцолсон байна. Коронавирусын цар тахлын үед таргалалт, чихрийн шижин, зүрх судасны өвчтэй хүмүүс хүндэрч нас барах магадлал нь улам бүр нэмэгдсээр байна.

Эрүүл мэндийн яамнаас гаргасан КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(COVID-2019)-ЫН ҮЕИЙН ЭМНЭЛЗҮЙН ТҮР ЗААВАР-ын 2.3.5 ЭРСДЭЛТЭЙ БҮЛЭГ-т зааснаар зүрх судасны архаг өвчтэй, зүрхний архаг дутагдалтай, зүрхний төрөлхийн гажиг, бодисын солилцооны хам шинжтэй, чихрийн шижин өвчин, хэт тарган иргэдийг онцгой анхаарахыг сануулсан байна.

Манай улсад 2012-2017 оны хооронд амтат ус, ундааны үйлдвэрлэл 30 хувиар, жимсний шүүстэй харьцуулахад хийжүүлсэн ундааны үйлдвэрлэл эрс өссөн. Мөн Монгол Улсын 2012 оны өрхийн чихэрлэг ундааны зардлыг 2015 оныхтой харьцуулахад 41 хувиар өссөн нь ноцтой үзүүлэлт юм. 2020 оны байдлаар нийт хүн амын сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь 31.7 мянган тонн байсан бол нийт үйлдвэрлэл /сахар, чихрийн зүйлийн хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг энэ бүлэгт шилжүүлж тооцсон (ёотон-1.0, хатуу чихэр-0.96, шоколад, зөөлөн чихэр, зефир-0.46, жимсний чанамал, сироп-0.46, хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа-0.47)/ нь 192.6 мянган тонн байна. Нийт үйлдвэрлэлийг хэрэгцээнд харьцуулан хангамжийн түвшинг тооцоход сахар чихрийн зүйлийн хангамж 6 дахин их байна.

Энэ нь хэрэглэгчийн эрүүл мэнд ноцтой үр дагаварт хүрэхийг сэрэмжлүүлж байгаа баримт. Өвчилсөн үеийн оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх зардал нь асар их бөгөөд харин сэргийлэх, хамгаалах, хянахад чиглэсэн бодлогын зөв, мөн цаг үеэ олсон шийдэл, шийдвэр нь зардал бага ч үр дүн нь илүү их байдаг.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Амтат ус, ундааны хэт хэрэглээ нь таргалалт, жингийн илүүдэл, чихрийн шижин, зүрх судасны өвчин зэрэг үүсэх үндсэн шалтгаан болдгийг дээрх судалгаанууд харуулж байна. Монгол Улсын нийт бүс нутгийн түвшинд илүүдэл жин ба таргалалтын тархалт насанд хүрэгчид, ялангуяа хүүхдүүдийн дунд гамшгийн хэмжээнд хүртэл нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд тулгарч болзошгүй хамгийн том эрсдэл болсон байна. Хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнгээс харахад 2010 онд 15-49 насны эмэгтэйчүүдийн 32.9 хувь илүүдэл жин ба таргалалттай байсан бол уг үзүүлэлт 40 хувиар нэмэгдэж, 15-49 насны эхчүүдийн бараг тал (46.2%) хувь илүүдэл жин ба таргалалттай байна. Харин таргалалттай эмэгтэйчүүдийн эзлэх хувь 49 хувиар нэмэгдэж 11.1 хувиас 16.5 хувь болж өсчээ. Илүүдэл жин ба таргалалтын тархалт 15-49 насны эрэгтэйчүүдийн дунд 2010 оныг 2016 онтой харьцуулахад эрс нэмэгдэж 76 хувь, 2 эрэгтэй тутмын 1 нь илүүдэл жинтэй эсвэл таргалалттай байна. Таргалалттай эрэгтэйчүүдийн эзлэх хувь 2010 онд 5.9 хувь байсан бол хоол тэжээлийн үндэсний V судалгааны дүнгээр 2,4 дахин нэмэгдэж, 14.6 хувьд хүрчээ. Илүүдэл жинтэй эсвэл таргалалттай 15-49 насны эхчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь хот, хөдөөд ижил түвшинд өндөр, харин эхчүүдийн хувьд бүс нутгаар ялгаатай байв.

Хэрэв одоогийн энэхүү буруу дадал, хандлагыг өөрчлөхгүй бол илүүдэл жин ба таргалалт нь улс орны эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжийг бууруулах гол шалтгаан болохоор байна. Чихэр, өөх тосны агууламж өндөртэй хүнсний татварыг нэмэгдүүлэх, эсвэл шинээр бий болгох төрийн бодлого хэрэгжүүлж, зарим төрлийн хүнсний хүртээмжийг тодорхой хэмжээгээр хязгаарлах арга хэмжээг эрүүл бус хоол, хүнсний хэрэглээг бууруулах стратегийн нэг хэсэг болгон ашиглах боломжийг судлах хэрэгцээ шаардлага байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20 хувийн татвар ногдуулахыг уриалсан. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас чихэрлэг ундаанд онцгой албан татвар ногдуулах замаар илүүдэл жин, таргалалттай үр дүнтэйгээр тэмцэхийг зөвлөмж болгосны дагуу АНУ-ын ихэнх муж, Австрали, Мексик, Чили, Дани, Финлянд, Норвеги, Франц, Их Британи, Ирланд, Номхон далайн арлын

орнууд, БНСУ, Камбож, Өмнөд Африк зэрэг дэлхийн олон улсад чихэрлэг ундаанд онцгой албан татвар ногдуулаад байна. Эрүүл зохистой хооллолт, ус ундааны зөв хэрэглээ зэрэг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн болон төсвийн бодлогын үр нөлөөг үнэлэх зорилгоор Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хийсэн сүүлийн үеийн 11 тойм судалгаанаас үзэхэд амтат ус, ундааны татварын үр дүнд түүний хэрэглээ 20-50 хувиар буурдаг нь нотлогдсон байна. Татварыг амтат ундаанд тогтоон харин түүнийг орлох бүтээгдэхүүн жимс, ногооны хэрэглээг дэмжсэн нь тэдгээрийн хэрэглээг 10-30 хувиар нэмэгдүүлдэг байна.

Амтат ундаанд онцгой албан татвар ногдуулахын зорилгыг өргөн хүрээгээр авч үзвэл хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, тогтвортой хөгжлийн 17 зорилго, 2016-2030 хөтөлбөрийн 3.4.1-д зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин болон амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин (10000 хүнд ногдох)-ийг бууруулах зорилт орсон байдаг. Түүнчлэн энэ хуулийн зорилгод мөн татварын орлогыг нэмэгдүүлэх замаар, төсөвт орлого нэмэгдүүлэх ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, чихрийн шижин, зүрх судасны өвчлөл зэргийг бууруулах, түүнчлэн татварын орлогыг эрүүл мэндийн салбарт оруулах, таргалалт чихрийн шижингээс үүдэлтэй эрүүл мэндийн салбарт ирж буй ачааллыг бууруулах хэмээн үзэж байна. Чихэрлэг ундааны татварыг нэмэгдүүлэх нь мөн богино хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлэхээс гадна урт хугацаанд чихэрлэг ундааны хэрэглээг бууруулах 2 талын ач холбогдолтой. АНУ-ын хэд хэдэн муж, Европ, Ази-Номхон далай, Африкийн улсууд чихэрлэг ундаанд олон янзын татварын тогтолцоог нэвтрүүлээд байна. Эдийн засгийн хөгжлийн түвшнээс үл хамааран дэлхийн улс орнууд амтат ундаанд татварын бодлого хэрэгжүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Татварын бодлого хэрэгжүүлэх нь таргалалт, түүнтэй холбоотой халдварт бус архаг өвчнийг бууруулахад засгийн газраас хэрэгжүүлж болох хамгийн зардал багатай арга хэмжээнд тооцогддог. Хуулийн төсөл батлагдсанаар онцгой албан татвар ногдуулах бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, улсын төсвийн орлого нэмэгдэх, нэмэгдсэн орлогоос хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдол бүхий нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Тус аргачлалд өмнөх шатанд сонгон авсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

- “Тэг” хувилбар: Энэ хувилбарыг сонгож Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг орхиж болох боловч хуульд нэмэлт өөрчлөлт оруулахгүйгээр ард иргэдийг чихрийн шижин болон зүрх судасны өвчнөөс сэргийлэх, эрүүл мэндийг сайжруулах, цаашид гарч болох сөрөг үр нөлөөнөөс урьдчилан сэргийлэхэд хүндрэлтэй юм.

- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбар: Амтат ус, ундааны хор нөлөөг хүүхэд залууст сурталчлах, онцгой албан татварын нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгаагаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ

ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь олон нийтэд сурталчлах, таниулахад чухал тул энэ хувилбар зорилгод хүрэх нэг арга зам болж болох юм.

- Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар: Энэ хуулийн нэмэлт өөрчлөлт нь зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй, онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эх үүсвэрийн ашиглалт, үйл ажиллагаанд зохицуулалт болохгүй тул зорилго биелэгдэхгүй юм.

- Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар: Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбараар шийдвэрлэхгүй тул энэ хувилбарыг сонгох боломжгүй юм.

- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар: Уг хуулийн төсөл нь байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбарт хамааралгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Зардал, үр өгөөжийн харьцаа

Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
Хүний эрхийн суурь зарчимд нийцэж байгаа эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх		хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		хамааралгүй

<p>1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх</p>			<p>Нийцэж байгаа</p>
<p>1.2.Оролцоог хангах</p>			
<p>1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх</p>		<p>Үгүй</p>	<p>хамааралгүй</p>
<p>1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх</p>		<p>үгүй</p>	<p>хамааралгүй</p>
<p>1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага</p>			
<p>1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх</p>	<p>Тийм</p>		<p>хамааралгүй</p>

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх			хамааралгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх			хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх			хамааралгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх			хамааралгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх			шаардлагагүй

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх			хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			хамааралгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх			хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх			хамааралгүй

5.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------------	------------------	---------	---------

	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
1.Дэлхийн зах			Үгүй	
зээл дээр өрсөлдөх чадвар	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	тийм		Чихэрлэг ундааны хэрэглээг бууруулах
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	

3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	тийм		
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	тийм		татвар нэмэгдүүлснээр төсөв нэмэгдэнэ
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх			борлуулалтад хамааралгүй
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (ухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	

	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			хамааралгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх			хамааралгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			хамааралгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	тийм		татвар нэмэгдсэнээр чихэрлэг ундааны үнэ өснө
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх			хамааралгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх			хамааралгүй

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх			Нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх			хамааралгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх			хамааралгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Шинээр 403 нийгмийн ажилтны орон тоог бий болгох

1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх			ээрэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх			хамааралгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		Нийгмийн ажилтныг илүү чадавхжуулах
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх			Эерэг
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Татварын ерөнхий газар болон холбогдох төрийн байгууллагуудад үүрэг нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх			хамааралгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх			хамааралгүй
5.Нийтийн эрүүл мэнд,	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	тийм		Чихэрлэг ундааны хэрэглээ багассанаар эрүүл мэндэд тустай

аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	тийм		эрүүл хүнсний хэрэглээг хэвшүүлэх тустай
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх			хамааралгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх			үгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			хамааралгүй

	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх			хамааралгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх			хамааралгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх			хамааралгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх			Хамааралгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх			Хамааралгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх			Хамааралгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх			хамааралгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх			хамааралгүй

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх			Хамааралгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/ бууруулах эсэх			Хамааралгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх			Хамааралгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх			Хамааралгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх			Хамааралгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх			Хамааралгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх			Хамааралгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх			Хамааралгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар			Хамааралгүй

	нутагт сэргээр нөлөөлөх эсэх			
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх			Хамааралгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх			Хамааралгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх			Хамааралгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх			Хамааралгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх			Хамааралгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх			Хамааралгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх			Хамааралгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх			Хамааралгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг алдагдуулахгүйгээр			Хамааралгүй

	зохистой ашиглах эсэх			
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх			Хамааралгүй

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Австрали улсын туршлага

Австралийн Эрүүл мэндийн холбооноос гаргасан судалгаагаар чихэрлэг ундаа нь таргалалтын гол шалтгаан болохоос гадна шим тэжээл хамгийн бага хүнс гэж тодорхойлсон байна. Таргалалтын шалтгаанаас үүдэн урьдчилан сэргийлэх боломжтой, ужиг чихрийн шижин-2 хэлбэр, зүрхний өвчин, цус харвалт, хорт хавдрын эрсдлийг нэмэгдүүлдэг. Илүүдэл жинтэй иргэдийн учруулах эрүүл мэндийн салбар дахь зардлын хэмжээ улам бүр нэмэгдэж байна хэмээн судалгаагаар дүгнэсэн байна. 100 грамм элсэн чихэрт 40 центийн татвар ногдуулахад чихрийн хэрэглээг 12-18 хувиар бууруулж, төсвийн орлогыг 749-814 сая доллар төвлөрүүлнэ гэсэн тооцоолол гаргасан.

Жингийн илүүдэл Австрали улсын иргэдийн тулгамдсан асуудлын нэг болсон. Чихэрлэг ундаа нь өндөр илчлэгтэй боловч шим тэжээлгүй ба 375 граммын ундаанд 8-12 халбага элсэн чихэр буюу 33-50 грамм чихэр агуулагддаг байна. Австралийн эрүүл мэндийн холбооноос гаргасан тооцоогоор Австрали улс жилд 2.4 тэрбум литр чихэрлэг ундаа хэрэглэж буй нь Олимпын тэмцээн зохиодог 960 усан санг дүүргэх хэмжээтэй тэнцэнэ хэмээн дурдсан байна. Чихэрлэг ундааны гол хэрэглэгчид нь залуучууд, хүүхдүүд байгаа нь анхаарал татаж байна.

Хэрэв ямар нэг арга хэмжээ авахгүй бол 2025 он гэхэд таргалалтаас үүдсэн эрүүл мэндийн салбар дахь зардлын хэмжээ 29.5 тэрбум доллар болно. Илүүдэл жинтэй хүмүүсийн эрүүл мэндийн зардал хэвийн жинтэй хүмүүсээс 30 хувиар илүү байдгийг системтэй судалгаанууд харуулсан. Ийм учраас чихрийн шижин-2, зүрхний өвчин, цус харвалт, хорт хавдраас сэргийлэхийн тулд арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

Австрали улс нь татвар ногдуулахаар дараах байдлаар судалж байна.

1. Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнд татвар ногдуулах нь хэрэглэгчдэд дохио өгөхийн зэрэгцээ үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнд ногдох чихрийн агууламжаа бууруулна. Түүнчлэн татварын орлого нэмэгдэх ба түүнийг нь эрүүл бус бүтээгдэхүүнээс татгалзах, хэрэглэгчдэд ойлгуулах ажилд зарцуулна.

2. Чихэрлэг ундааны татварт жимсний шүүс, сүү, сүүн бүтээгдэхүүн, сэргээх ундааг оруулахгүй.

3. Австралийн эрүүл мэндийн холбооны загвараар чихэрлэг ундааны хэрэглээг 12-18 хувиар (27596-43804 тонн чихрийн хэрэглээ) бууруулж төсөвт 749-814 сая долларын орлого төвлөрүүлнэ.

Татвар ногдуулах тооцоог 100 грамм чихэрт 0.40 долларын буюу ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу жижиглэнгийн худалдааны үнийг 20 хувь өсгөхүйц байдлаар хийв. Ингэснээр жижиглэн худалдааны дэлгүүр дэх чихэрлэг ундааны үнэ 20 хувь өсөх ба 375 граммын кола ундаанаас (40 грамм чихэр агуулдаг) 0.16 долларын татвар төсөвт орно.

Чихэрлэг ундааны хэрэглээ, ундаан дахь чихрийн агууламж буурах нь таргалалт болон түүнээс үүдсэн эрүүл мэндийн зардал буурна. Өмнөх тооцооллоор чихэрлэг ундааны татвар ногдуулснаар жижиглэнгийн үнэ 20 хувь өсч таргалалтыг 2 хувиар бууруулж, эрүүл мэндийн салбарын зардал 609 сая доллараас 1.73 тэрбум доллар гэж үзсэн. 25 жилийн хугацаанд чихрийн шижин 2 төрөл 16000, зүрхний өвчлөл 4400, цус харвалт 1100 тохиолдлоор цөөрнө хэмээн үзэж байна.

Их Британи улсын ундаанд ногдуулсан татварын бодлого, үр дүн

Их Британи ундааны татварыг 2016 онд батлан 2018 оноос хүчин төгөлдөр мөрдүүлэхээр баталсан. Хоёр жилийн хугацаанд цөөн тооны брэндээс бусад үйлдвэрлэгчид татвар ногдуулах чихрийн агууламжтай ундааны найрлагад өөрчлөлт оруулсан. Хөдөлмөрийн эдийн засгийн хүрээлэнгийн (IZA Institute of Labor Economics) тооцоогоор үйлдвэрлэлийн 80 илүү хувь нь энэхүү өөрчлөлтийг хийсэн. Хуулинд зааснаар 100 мл ундаанд 5 грамаас бага чихэр агуулсан бол татваргүй, 5-8грамм чихрийн агууламжтай бол литр тутам 0.18 фунт стерлинг, 8 граммаас дээш бол литр тутам 0.24 фунт стерлингийн татвар ноогдуулна. Уг татварыг 100 хувь хэрэглэгч рүү шилжүүлбэл 330 мл чихрийн агууламж өндөртэй лаазтай хийжүүлсэн ундааны үнэ 9.4 центээр, 2 литрийн шилтэй бол 57.6 центээр өсөхөөр байсан. Чихрийн агууламжаар ялгаатай татвар ногдуулах нь уг татварын гол зорилго болох эрүүл бүтээгдэхүүн, эрүүл хэрэглээг дэмжихтэй шууд холбоотой болсон.

Британийн ундааны холбооны мэдээллээр 2019 онд 13.7 тэрбум литр ундаа хэрэглэсэн байна. Үүний 38.6 хувь нь хийжүүлсэн ундаа, сироп 20.8 хувь, савласан ус 20.6 хувь, шүүс 7.1 хувь, цэвэр жимсний шүүс 6.5 хувь, энергийн ундаа 6.3 хувь. (BSDA, 2020)

Их Британийн засгийн газар чихэрлэг ундааны татварын энэхүү амжилттай хэрэгжилтээс үндэслэн хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бусад бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах дараагийн бодлогыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

2015-аас 2019 оны 4-р сар хүртэл ундааны долоо хоногийн хэрэглээ 110 сая литр хэвээр байхад түүнээс авах илчлэгийн хэмжээ 23 тэрбум калори байсан бол 15 тэрбум калори болж буурсан нь татвар гол зорилгоо биелүүлж буйг харуулж байна. Түүнчлэн татвар ногдуулснаар үнэ өссөн ундаануудын борлуулалт 18 хувиар буурсан. Нийт хэрэглээ буураагүй тул энэхүү борлуулалтын бууралт татваргүй буюу эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ундаа руу шилжсэн. Тодруулбал чихэрлэг ундаа нь орлуулагдах бусад бүтээгдэхүүн болох цэвэр ус, бусад ундаа, сүү, жүүс зэргээр үнийн өсөлтөөс хамааран хэрэглээг өөрчлөх бүтээгдэхүүн юм.

Их Британи улсын хүрсэн үр дүн

Ундаанд чихрийн агууламжаас хамааруулан татвар ногдуулсан нь хүн амын эрүүл мэндийн талаасаа сайн үр дүнд хүрсэн. Гол 100 брэндийн ундааны борлуулалтаас үзвэл долоо хоногт авч байсан 23 тэрбум калори 15 тэрбум болж буурсан нь нэг иргэний жилд ундаанаас авдаг илчлэгийг 6500 калориор бууруулсан.

2 литрийн хэмжээтэй чихэртэй ундаа жижиглэнгийн худалдааны цэгт 1.30 паундаар борлуулагддаг. Хэрэв дэлгүүр ундаа бүрээс 30 центийн ашиг хийдэг гэвэл 27.8 хувийн ашгийн маржинтай гэсэн үг. Ундааны чихрийн агууламжаас хамаарсан татвар ногдуулбал 57.6 цент болох ба үүнийг хэрэглэгч рүү бүрэн шилжүүлнэ гэвэл үнэ 1.88 паунд болно. Энэ тохиолдолд жижиглэнгийн дэлгүүрийн ашгийн маржин 19.1 хувь болж буурсан харагдана. 27.8 хувийн ашгийн маржингаа хадгалахын тулд дахин 22 центээр үнэ өсгөх ба ингэснээр үнэ 2.10 паунд болно. Ингэснээр татварын хэрэглэгч рүү очих нөлөө 139 хувь болно.

Өмнөд Африкийн БНУ-ын туршлага

Өмнөд Африкт сүүлийн 30 жилийн хугацаанд чихэрлэг ундааны хэрэглээ тогтвортой нэмэгдсэнээр бүс нутагтаа таргалалтын түвшингээр тэргүүлэгч улс болоод байна. Энэ асуудалтай тэмцэх зорилгоор Өмнөд Африкийн засгийн газар 2016 оны 7 сард 100 мл тутамд 4 гр-аас их сахарын агууламжтай чихэрлэг ундаанд 20%-ийн татвар ногдуулах шийдвэрийг гаргасан байна. Татварын бодлого 2017 оны 4-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр энэ төрлийн татварыг хэрэгжүүлсэн Африк тивийн анхны улс болсон. Чихэрлэг ундаанд 20%-ийн татвар ногдуулснаар дараагийн 20 жилийн хугацаанд нэг хүнд хоногт ногдох илчлэгийн хэрэглээг 8.6 ккал-аар эмэгтэйчүүдийн дундах таргалалтыг 2.4%, эрэгтэйчүүдийн дундах таргалалтын тархалтыг 3.8%-иар, чихрийн шижингийн тархалтыг 4.0%-иар, цус харвалтын тархалтыг эрэгтэйчүүдэд 1.03%-иар, эмэгтэйчүүдэд 1.55%-иар, цус харвалтын шалтгаант нас баралтыг эрэгтэйчүүдэд 1.07%, эмэгтэйчүүдэд 1.76%-иар тус тус бууруулах боломжтой гэж тогтоожээ

БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Ундааны чихрийн агууламжид ногдуулсан татварыг Франц, Их Британи, Энэтхэг, Мексик гэсэн том эдийн засагтай орнууд улсын хэмжээнд, АНУ-н Бэркли, Филадельфи, Боулдер зэрэг зарим хотуудад ногдуулж байна. Татварыг ундаан дахь чихрийн агуулгын хэмжээнээс хамааруулсан болон нийт ундаанд үнийн дүнд ногдуулсан гэсэн хэлбэрийг ашигладаг.

- Франц улс 2012 онд бүх төрлийн ундаанд литр тутам 7.16 центийн татвар ногдуулсан ба 2018 онд үүнийгээ агуулагдах чихрийн хэмжээнээс хамаардаг болгон өөрчилсөн. Berrardi et al (2016), Etile et al (2018) нар татвар ногдуулснаар хэрэглэгчид очих үнийн дарамтыг судалсан.

- Мексик 2014 оны 1-р сард амтат ундаанд татвар ногдуулсан ба энэ нь ундааны үнийг 9 хувиар өсгөсөн. Үйлдвэрлэгчид харин 14 хувиар үнээ өсгөсөн. Colchera et al (2015) татвартай ундааны борлуулалт 6 хувиар буурсан бол татваргүй ундааны борлуулалт 4 хувиар өссөнийг панел дата анализаар дүгнэсэн. Artega et al (2017) татвар ногдуулсан ундааны борлуулалт 3.8 хувиар буурсан тухай судалгааны дүгнэлт гаргасан.

- Чили улс 2014 онд 100 мл ундаанд 6.25 грамм чихэр агуулсан бол үнийн дүнгийн 18 хувьтай тэнцэх татвар, 100 мл ундаанд 6.25 граммаас бага чихэртэй бол 10 хувийн татвар ногдуулсан. Caro et al (2018) чихрийн агууламж өндөр буюу татвартай ундааны үнэ 2 хувиар өсч борлуулалт 3.4 хувиар буурсан. Харин чихрийн агууламж багатай ундааны үнэ болон борлуулалт өссөн нөлөө үзүүлснийг мөн нотолсон.

- Зарим улс татварыг зөвхөн зөөлөн ундааг хамруулан тогтоосон байсан бол зарим нь нэмэгдэл сахартай бүх төрлийн ундаанд (амтлаг сүү, жимсний ундаа, амтлаг тараг гэх мэт) болон тэдгээрийг бэлтгэх түүхий эдэд (жишээлбэл, чихэрлэг ундаа найруулах нунтаг, сироп гэх мэт) ногдуулсан байна.

Татварын түвшин улс орон бүрт өөр байлаа. Жишээлбэл, АНУ-ын янз бүрийн мужид татварын хэмжээг 0-7%-иар тогтоосон байлаа. Онцгой татварын хэмжээ Барбадос, Камбож, Лаос, Соломоны арлууд, БНСУ-д 10%-иар тогтоосон бол хамгийн өндөр түвшинг Өмнөд Африкт (20%), Бангладеш (25%), Микронезийн холбооны улс (25%), Кирибати (40%) улсуудад тогтоожээ. Номхон далайн арлын орнуудад чихэрлэг ундаанд импортын татвар тогтоосон байв.

Эдгээр улс орнуудын амтат ундаанд ногдуулсан татварын бодлогыг дүгнэхэд бодлогын зорилго, хамрах хүрээ чухал болохыг харж байна. Аливаа татварын бодлогыг хэрэгжүүлэхэд зорилго, тэдгээрийн эрэмбэ, хүрэх үр дүн, урт хугацааны нөлөө гэсэн олон талаас харгалзан үзэх нь зүй.

Хүснэгт 1 Улс орнуудын чихэрлэг ундаанд татвар ногдуулсан байдалд хийсэн тойм, татварын төрөл, ногдуулсан бүтээгдэхүүнээр

Улс банкны ангилал)	(Дэлхийн Татвары н төрөл	Татварын түвшин	Татвар ногдуулса н бүтээгдэхү үн	Татвараас чөлөөлсө н бүтээгдэх үүн	Татвар ногдуу лсан он
<u>Зүүн ази, номхон далайн бүс</u>					
Америкийн (III) (22)	Самао Импортын татвар, онцгой татвар	354.9 мл тутамд 0.15 ам.долла р	Бүх төрлийн хийжүүлсэн ундаа, сироп	-	1963
Австрали (IV) (23, 24)	Бараа, үйлчилгэ эний татвар	Барааны үнийн 10%	Зөөлөн ундаа, амтлаг сүү	Шинэ бүтээгдэхү үн	2001
Камбож (II) (25)	Онцгой татвар	10%	Бүх төрлийн чихэрлэг ундаа	-	2004

Күүкийн арлууд (IV) (26)	Онцгой татвар	Ундаанд агуулагдах 1 кг сахар тутамд 9.8 шинэ зеланд доллар	Нэмэлт сахар агуулсан бүх төрлийн ундаа	Сахар орлуулагчт ай ус	2014
Фижи (III) (26)	Импортын татвар	32%	Зөөлөн ундаа	-	2011
Францын Полинези (IV) (27)	Импортын татвар, онцгой татвар	Дотоодын үйлдвэрийн 1 литр тутамд 40 франк; импортын чихэрлэг ундааны 1 л тутамд 60 франк	Чихэрлэг ундаа	-	2002, 2011
Кирибати (II) (28)	Онцгой татвар	40%	Чихэрлэг ундаа, бүх төрлийн амт оруулагч	-	2014
БНСУ (IV) (29)	НӨАТ	10%	Бүх төрлийн боловсруулсан хүнс		
Лаос (II) (30)	Онцгой татвар	10%	Чихэрлэг ундаа	-	2013
Маршалын арлууд (III) (72)	Импортын татвар	Хийжүүлсэн ундааны 295.7 мл тутамд 0.0014 ам.доллар; хийжүүлээгүй зөөлөн ундаанд	Сахарын нэмэлттэй хийжүүлсэн болон хийжүүлээгүй ундаа	-	2004, 2016

		6.666%-ийн татвар.			
Микронезийн холбооны улс (II) (72)	Импортын болон онцгой татвар	25%	Сахарын нэмэлттэй ундаа, түүхий эд	-	2004
Науру (III) (31)	Импортын татвар	30%	Сахар, сахар агуулсан ундаа	Ус	2007, 2010
Хойд марианы арлууд (IV) (32)	Онцгой татвар	29.5 мл тутамд 0.005 ам.доллар	Хийжүүлсэн болон хийжүүлээгүй зөөлөн ундаа	Жимсний шүүс, ногооны шүүс, савласан ус, цай, цайн бүтээгдэхүүн	1979, 1995
Шинэ каледони (IV) (26)	Импортын татвар	Жимсний шүүсэнд 5%, зөөлөн ундаанд 10%	Зөөлөн ундаа, жимсний шүүс		
Палау (IV) (26)	Импортын татвар	Литр тутамд 0.28175 ам.доллар	Сахарын болон бусад төрлийн амт оруулагчтай чихэрлэг ундаа	Ус, жимсний шүүс, ногооны шүүс	2015

Папуа шинэ гвиней (II) (33)	Импортын татвар	10% and 15%	Жимсний агууламжтай сахарын нэмэгдэлтэй ус, ундаа		2012
Самоа (III) (27)	Импортын болон онцгой татвар	Литр тутамд 0.40 Самоагийн Тала (0.16 ам.доллар)	Хийжүүлсэн ундаа, бүх төрлийн спиртгүй ундаа, сироп	-	1984, 2001
Соломоны арлууд (II) (26)	НӨАТ	10%	Бүх төрлийн чихэрлэг ундаа		
Тонга (III) (26)	Онцгой татвар	Литр тутамд 1 Тонга Па'анга (0.47 ам.доллар)	Хийжүүлсэн ундаа		2013
Вануату (II) (26)	Онцгой татвар	Литр тутамд 50 Вануатугийн Вату (0.46 ам.доллар)	Сахар болон бусад төрлийн амт оруулагчтай хийжүүлсэн ундаа	-	2014
<u>Европ</u>					
Дани (IV) (34)	Онцгой татвар	Литр тутамд 1.64 Дани Крон	Зөөлөн ундаа	-	1930-2014
Финланд (IV) (35)	Онцгой татвар	Литр тутамд 0.22 Евро	0.5%-ын сахарын агууламжта	Ус, сүү	1940; 2014

			й зөөлөн ундаа		
Франц (IV) (35, 36)	Он цг ой та тв ар	2012 онд 100 литр тутамд 7.16 Евро; 2016 онд 100 литр тутамд 7.53 Евро	Сахарын нэмэгдэлтэ й бүх төрлийн ундаа	Сүү, эмнэлгийн зориулалт ай сахарын нэмэгдэлтэ й ундаа, цай, кофе	2012, 2016
Унгар (IV) (35)	Он цг ой та тв ар	Зөөлөн ундааны литр тутамд 7 Унгар Форинт; Сиропны литр тутамд 200 Унгар Форинт	Зөөлөн ундаа, сироп (100 мл-т >8 гр- ээс их сахарын агууламжта й)	Жимс, ногооны > 25% агууламжт ай ундаа; Сүүний >50% агууламжт ай ундаа	2011, 2013
Ирланд (IV) (37)	Он цг ой та тв ар	Англитай ижил			2018 оны 4 дүгээр сараас
Норвеги (IV) (38)	Онцгой татвар	1 кг сахар тутамд 7.66 Норвеги Крон	Сахар, сахарын нэмэлттэй бүтээгдэхүү н	-	2016
Англи (IV) (39)	Онцгой татвар	100 мл-т ≥8 гр сахарын агууламжт ай ундааны литр тутамд 24 Пенс; 5 гр<сахар> 8 агууламжт ай	Зөөлөн ундаа	Жимсний ундаа, сүүн бүтээгдэхү үн	2018 оноос

		ундааны литр тутамд 18 Пенс			
<u>Өмнөд Ази</u>					
Бангладеш (II) (40)	Боловср уулалты н татвар	25%	Зөөлөн ундаа, хүч тамирын ундаа	-	2014
<u>Латин Америк, Карибын тэнгисийн орнууд</u>					
Барбадос (IV) (41)	Онцгой татвар, НӨАТ	Онцгой татвар: 10% НӨАТ: 11.75%	Чихэрлэг ундаа	100% байгалийн сахартай жимсний шүүс	2015
Чили (IV) (42)	Ad- valorem tax	Зөөлөн ундаанд 18% (100 мл-т >6.25 гр сахартай); амтлаг усанд 10% (100 мл-т <6.25 гр сахартай)	Зөөлөн ундаа, амтлаг ус, спортын ундаа	-	2015
Доминикан (III) (43)	Онцгой татвар	Литр тутамд 0.20 Зүүн Карибын доллар; хүч тамирын	Зөөлөн ундаа, хүч тамирын ундаа	-	2015

		ундаанд 10%			
Мексик (III) (44)	Онцгой татвар	Литр тутамд 1 Мексикий н Песо	Чихэрлэг ундаа, сахарын агууламжта й нунтаг сироп	Сүүн бүтээгдэхү үн, илчлэггүй ундаа	2014
Сан Хелены арлууд (IV) (45)	Онцгой татвар	Литр тутамд 0.75 Сант Хелены Фунт (0.97 ам.долла р)	Литр тутамд >15 гр сахарын агууламжта й хийжүүлсэн ундаа	-	2014
<u>Африк</u>					
Маврикий (III) (47)	Онцгой татвар	1 гр сахар тутамд 0.03 Маврикий н Рупи	Хийжүүлсэн ундаа, жимсний ундаа, сироп	-	2013, 2014
Өмнөд африк (III) (46)	Онцгой татвар	20%	Чихэрлэг ундаа	-	2017
<u>Хойд Америк</u>					
(IV) (48, 50, 51, 73)	Олон төрөл	0-7%	Сахарын нэмэлттэй чихэрлэг ундаа, сироп, нунтаг сироп	Хот, муж улсаас хамаарч олон төрөл	1920, 2015
Албани, Калифорни					

Беркели, Калифорни	Онцгой татвар	29.6 мл (1 унц) тутамд 0.01 ам.доллар	Илчлэг амтлагч, чихэрлэг ундаа	Жимс, ногооны 100% концентрат, байгалийн амт оруулагч, сүү, эмнэлгийн зориулалттай ундаа	2015
Күүк, Иллинойс	Онцгой татвар	29.6 мл тутамд 0.02 ам.доллар	Зөөлөн ундаа		2017 оны 7 сар
Боулдер, Колорадо	Онцгой татвар	29.6 мл тутамд 0.02 ам.доллар	Зөөлөн ундаа		2017 оны 7 сар
Филадельфи, Пенсилвани	Онцгой татвар	29.6 мл тутамд 0.015 ам.доллар	Чихэрлэг ундаа, илчлэг амт оруулагчид	Эмнэлгийн зориулалттай ундаа; $\geq 50\%$ сүүн бүтээгдэхүүн, $\geq 50\%$ жимс ногооны бүтээгдэхүүн	2016, 2017
Сан Франциско	Онцгой татвар	29.6 мл тутамд 0.01 ам.доллар	Зөөлөн ундаа		2018 оноос
Оакланд	Онцгой татвар	29.6 мл тутамд 0.01 ам.доллар	Зөөлөн ундаа		2017 оны 7 сар

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс орнуудад хандан таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20%-ийн татвар ногдуулахыг уриалсан. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас чихэрлэг ундаанд онцгой албан татвар ногдуулах замаар илүүдэл жин, таргалалттай үр дүнтэйгээр тэмцэхийг зөвлөмж болгосны дагуу АНУ-ын ихэнх муж, Австрали, Мексик, Чили, Дани, Финлянд, Норвеги, Франц, Их Британи, Ирланд, Номхон далайн арлын орнууд, БНСУ, Камбож, Өмнөд Африк зэрэг дэлхийн олон улсад чихэрлэг ундаанд онцгой албан татвар ногдуулаад байна. Эрүүл зохистой хооллолт, ус ундааны зөв хэрэглээ зэрэг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн болон төсвийн бодлогын үр нөлөөг үнэлэх зорилгоор Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хийсэн сүүлийн үеийн 11 тойм судалгаанаас үзэхэд амтат ус, ундааны татварын үр дүнд түүний хэрэглээ 20-50 хувиар буурдаг нь нотлогдсон байна. Татварыг амтат ундаанд тогтоон харин түүнийг орлох бүтээгдэхүүн жимс, ногооны хэрэглээг дэмжсэн нь тэдгээрийн хэрэглээг 10-30 хувиар нэмэгдүүлдэг байна.

Чихрийн агуулгамжаас хамааруулан татвар ногдуулахад дараах сонголтууд гарна.

1. Үйлдвэрлэгч болон импортлогчид бүтээгдэхүүний жор, найрлагад өөрчлөлт оруулахгүйгээр татварын өсөлтийг хэрэглэгч рүү бүрэн шилжүүлэх-зарим бүтээгдэхүүний үнийг татвараас илүү хэмжээгээр өсгөх, зарим бүтээгдэхүүний үнийг татвартай ижил хэмжээгээр өсгөх сонголтууд гарах ба үнийн өсөлтөөс хамаарсан борлуулалтыг бууралтыг нөхөхүйц борлуулалтын өсөлт хийх арга замыг хайна. Гэхдээ орлуулах бүтээгдэхүүнтэй учраас татварыг хэрэглэгч рүү бүрэн шилжүүлэх нь уг бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг бууруулах тул өрсөлдөгчид байр сууриа алдана.
2. Үйлдвэрлэгч болон импортлогчид бүтээгдэхүүний жор, найрлагад өөрчлөлт оруулах-татвар ногдох бүтээгдэхүүний жор найрлагыг өөрчлөх замаар татвар ногдох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг бууруулна. Ингэснээр эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, цаашдаа ч хэрэглэгчийн худалдан авах төлөв байдлыг өөрчилнө.

Татварын бодлого хэрэгжүүлэх нь таргалалт, түүнтэй холбоотой халдварт бус архаг өвчнийг бууруулахад засгийн газраас хэрэгжүүлж болох хамгийн зардал багатай арга хэмжээнд тооцдог. Ялангуяа хүүхдийн таргалалтыг бууруулахад ундааны найрлага дахь чихрийг бууруулах, үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүний жор найрлагад өөрчлөлт оруулах давхар ач холбогдолтой. Хуулийн төсөл батлагдсанаар онцгой албан татвар ногдуулах бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж, улсын төсвийн орлого нэмэгдэх, нэмэгдсэн орлогоос хүн амыг халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдол бүхий нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно. Чихэрлэг ундаа нь түгээмэл, орлуулах олон бүтээгдэхүүнтэй тул иргэдийн ундны хэрэгцээнд сөрөг нөлөөгүй. Татваргүй эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх боломж нэмэгдэнэ.

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2021 он

ГАРЧИГ

УДИРТГАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН
БАЙДАЛ

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "... хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид "хууль тогтоомж" гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх..." гэж заасан.

Хуулийн дээрх зорилтын хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Аргачлал батлах тухай" 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд холбогдох судалгааг хийсэн болно.

Энэхүү судалгаагаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, ДЭМБ-ын 2016 оны тайланд чихэрлэг ундаанд татвар ногдуулах нь таргалалт, чихрийн шижин-2, шүдний өвчлөлийг бууруулах нөлөөтэйг дурьдан улс орнуудад хандан зөвлөмж гаргасан. "Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хоол тэжээлд чиглэсэн санхүүгийн бодлого" тайланд дурдсанаар чихэрлэг ундааны жижиглэнгийн худалдааны үнийг 20 хувь нэмэгдүүлэхүйц татвар ногдуулах нь тэр хэмжээгээр хэрэглээг бууруулдаг гэжээ. Чихэр гэдэг нь моносахарид (глюкоз, фруктоз), дисахарид (сахароз) гэсэн хэлбэрээр аливаа үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүндээ хийж буй чихэр болон органик гаралтай буюу зөгийн бал, сироп, жимсний шүүс, жимсний шүүсний концентрацийг багтаана. ДЭМБ-ын Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх газрын дарга доктор Дуглас Бэтчер "чихэрлэг ундаа хэрэглэх нь дэлхий даяар таргалалт болон чихрийн шижингийн өвчлөлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Ийм учраас чихэрлэг ундаанд татвар ногдуулах нь хүн амын эрүүл мэндийг хамгаалахаас гадна эрүүл мэндийн салбарын зардлыг хэмнэх, бусад үйлчилгээнд хөрөнгө оруулах боломжийг олгоно" гэж хэлсэн байдаг. 1975 онтой харьцуулахад дэлхий даяар таргалалт 3 дахин нэмэгдэн 2016 оны байдлаар 1.9 тэрбум насанд хүрсэн иргэд жингийн илүүдэлтэй тэр дотроо 650 сая нь таргалалттай байна. Таргалалтаас шалтгаалсан нас баралт хоол тэжээлийн дутагдлаас болсон нас баралтыг давсан байдлыг ДЭМБ тайланд дурьджээ.

Тодорхойлолт: Биеийн жингийн индексийг (БЖИ) тооцохдоо биеийн жинг биеийн өндрийн квадратад хувааж тооцдог. ДЭМБ-ын зөвлөмжид БЖИ 25 болон түүнээс доош бол хэвийн, 25-тай тэнцүү буюу түүнээс их байвал жингийн илүүдэлтэй, БЖИ 30-тай тэнцүү буюу илүү байвал таргалалттай гэж үздэг.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор улс орнуудын засгийн газар эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хоол хүнсний хэрэглээг зохицуулахад зарим төрлийн татварыг ашигладаг. Ялангуяа хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй архи согтууруулах ундаа, тамхи, хатуу түлш, чихэрлэг ундаанд татвар ногдуулдаг. Эдгээр бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сурталчилгаа таниулга хийх зэрэг олон ажилд үүнээс бүрдсэн орлогыг зарцуулдаг. ДЭМБ-ын судалгаанд чихэрлэг ундааны хэрэглээ нь чихрийн шижин-2, илүүдэл жин, таргалалт, шүдний өвчлөлийн үндсэн шалтгаан болдог ба чихэрлэг ундаанд татвар ногдуулснаар орлогын түвшин багатай бүлгүүдийн хэрэглээ буурч өрхийн төсөвт эзлэх эрүүл мэндийн зардал буурах зэргээр илүү сайн

үр дүн үзүүлдэг тухай дурдсан. Түүнчлэн чихэрлэг ундаанд татвар ногдуулснаар таргалалт, чихрийн шижин-2, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хэрэглээг бууруулахад чухал нөлөөтэйг тэмдэглэсэн. Судалгааны үр дүнд чихэрлэг ундааны жижиглэнгийн худалдааны үнийг 20% өсгөхүйц татвар ногдуулснаар хэрэглээ мөн 20 орчим хувиар буурдаг гэжээ.

Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний хэрэглээг бууруулснаар дараах үр дүн гардаг.

Хүн амын хувьд:

- ✧ Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний талаарх мэдлэг мэдээлэлтэй болсноор насанд хүрэгчид төдийгүй хүүхэд, залуучуудад эрүүл бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэх соёл хэвшдэг.
- ✧ Чихэрлэг ундаанд зарцуулах зардлаа бууруулснаар бусад орлуулах бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэнэ.
- ✧ Чихэрлэг ундааны хэрэглээнээс шалтгаалсан шүдний өвчлөл, чихрийн шижин, таргалалт бусад дам шалтгаан болдог өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Засгийн газрын хувьд:

- ✧ Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүргийн дагуу эрүүл мэндэд эрсдэл учруулагч хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах ёстой. Үүнийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга нь татвар бөгөөд богино хугацаанд төсвийн орлого нэмэгдэнэ.
- ✧ Тогтвортой хөгжлийн (зорилт 1), Ядуурлыг бууруулах (зорилт 3), Эрүүл мэндийг дэмжих (зорилт 12), Хариуцлагатай хэрэглээг дэмжих (зорилт 17), Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд чихэрлэг ундааны татварын бодлого бүрэн нийцнэ.
- ✧ Урт хугацаанд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний хэрэглээг бууруулснаар хүн амын эрүүл мэнд сайжрах ба эрүүл мэндийн салбарт энэ төрлийн өвчлөлийг учруулдаг зардлын дарамт буурна.
- ✧ Татвараас бүрдсэн орлогын тодорхой хэсгийг эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнийг таниулах, хэрэглээнээс үүдсэн өвчлөлтэй тэмцэх ажилд зарцуулна.
- ✧ Чихэрлэг ундааны татварын сайн үр нөлөөнд тулгуурлан эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бусад бүтээгдэхүүний хэрэглээг ч өөрчлөх дараагийн бодлогыг хэрэгжүүлэх боломжтой болно.

Үйлдвэрлэгч, импортлогчдын хувьд:

- ✧ Богино хугацаанд: үйлдвэрлэж, импортолж буй чихэрлэг ундаанд татвар ногдуулах нь борлуулалт буурах нөлөөтэй боловч эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бусад ундааны борлуулалт нэмэгдэнэ.
- ✧ Урт хугацаанд: чихэрлэг ундааны жор найрлагад өөрчлөлт оруулснаар эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний оронд бусад орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортын хэмжээ нэмэгдэнэ. Энэ нь бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагын нэгэн бодит алхам болно.

Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд:

- ✧ Иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн сайн дурын аливаа нэгдэл нь нийгмийн өмнө тулгамдсан аливаа асуудлыг шийдэлцэж, хувь нэмрээ оруулах зорилготой байдаг. Таргалалт, шүдний өвчлөл, зүрх судасны өвчлөл, чихрийн шижинтэй

тэмцэх нь нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн тучраас эрүүл амьдралын хэв маяг, эрүүл хэрэглээ, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнг дээшлүүлэх, өвдсөний дараах сэргээн засах үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлвэл илүү үр дүнтэй болно.

Халдварт бус өвчин нийт нас баралтын 92% (2020) болдог тул хүн амын хувьд ч засгийн газрын хувьд эдийн засаг нийгмийн үр дагавар ихтэй асуудал юм. Таргалалт, жингийн илүүдлийн чухал хүчин зүйлийн нэг нь чихэр, өөх тос ба насанд хүрэгчид болон хүүхдэд ялгаагүй эрсдэл учруулж байна. НЭМХ-ийн судалгаагаар 6-11 насны хүүхдийн 28.6% илүүдэл жинтэй, 6.4% таргалалттай бол насанд хүрэгчдийн хувьд энэ тоо 47.3%, 15.4% байна. Түүнчлэн, чихрийн шижингийн өвчлөл 2019 оны байдлаар 10000 хүнд ноогдох нь 111.4 байгаа нь 28.5-аар нэмэгдсэн бол, шүдний өвчлөл 10 жилийн дунджаас 1.4 пунктээр нэмэгдсэн байна. (Эрүүл мэндийн үзүүлэлт, ЭМХТ, 2019)

Хоол тэжээлийн хэрэглээний чихэр ихтэй бүтээгдэхүүн бол амтат ус, ундаа юм. НЭМХ-ийн судалгаагаар 10 хүүхэд тутмын 7 нь өдөр тутам хэрэглэдэг гэсэн нь чихэрлэг ундааны хэрэглээ өсч буйг харуулж байна. Өрхийн мөнгөн орлого зарлагын судалгаагаар нэг өрхийн сарын хэрэглээний амтат ус, ундааны зардал нь жил бүр өсч ирсэн ба 2020 оны 12 сарын байдлаар цэвэр ус, ундаа, жимсний шүүсэнд 11751 төгрөг зарцуулж байна. Мөн элсэн чихэр, амттанд 12879 төгрөг, цай кофенд 5196 төгрөг байгаа нь хүн амын чихрийн хэрэглээ хэр өндөр буйг илтгэнэ. Ундаа үйлдвэрлэгчдийн маркетинг сурталчилгаа идэвхитэй байх нь чихэрлэг ундааны хэрэглээг тасралтгүй нэмэгдүүлж байна. Өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад Монгол улсын чихэрлэг ундааны хэрэглээ бага мэт боловч сүүлийн 10 жилийн хэрэглээний өсөлт өндөр байгаа нь анхаарах асуудал болж байна. Статистикийн газрын Өрхийн мөнгөн орлого зарлагын судалгааг харахад орлогын түвшин багатай өрхийн орлогод эзлэх чихэрлэг ундаа, усны зардал өндөр байна.

Чихэрлэг ундааны үйлдвэрлэл болон хэрэглээний сүүлийн 10 жилийн статистикаас харахад эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй ундааны хэрэглээг бууруулах татварын бодлого зайлшгүй хэрэгтэй байна. ДЭМБ-аас гаргасан халдварт бус өвчнийг бууруулах зөвлөмжид мөн чихэрлэг ундааны хэрэглээг бууруулах гол арга зам нь татвар ногдуулах гэдгийг дурдсан.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Жингийн илүүдэл, таргалалт түүний үр дагавар

Халдварт бус өвчний эрсдэлийн гол хүчин зүйл болсон жингийн илүүдэл, таргалалт сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж байна. ДЭМБ-ын халдварт бус өвчний 2014 оны тайланд дурдсанаар 1980-2014 оны хооронд эрэгтэйчүүдийн 11%, эмэгтэйчүүдийн 15% нь таргалалттай байна. ДЭМБ, ЮНИСЕФ, ДБ-ны хамтарсан мэдээллээр 5-аас доош насны 41 сая хүүхэд таргалалттай байна. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн хийсэн Хүн амын хоол тэжээлийн судалгаагаар 2010-2017 оны хооронд илүүдэл жин, таргалалтын тархалт 5 хүртэлх настай хүүхдүүдэд 6.6%-иас 12%, 7-12 настай хүүхдүүдэд 4.3%-иас 28%, 15-49 настай эрэгтэйчүүдэд 49.3%- иас 64%, 15-49 настай эмэгтэйчүүдэд 32.9%-иас 63% болж нэмэгдсэн байна.

Дэлхийн таргалалтын холбооноос гаргасан “Хүүхдүүдийн илүүдэл жин” судалгаанд 2020 онд 206 сая, 2030 он гэхэд 250 сая хүүхэд таргалалттай болно гэдгийг дурдаад хүн амын өсөлт, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй түргэн хоол, чихэрлэг ундаа гол нөлөөлөгч хүчин зүйл болохыг дурджээ. ЭМЯ, ДЭМБ, НЭМҮТ-ийн 2019 хийсэн судалгаанд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 32% нь илүүдэл жинтэй, 16.6% нь таргалалттай ба эмэгтэйчүүдийн хувьд 30.5% илүүдэл жинтэй, 20.4% нь таргалалттай байна гэсэн ямар нэг арга хэмжээ авахгүй бол хүн амын эрүүл мэндэд учрах эрсдэл улам нэмэгдэхийг харуулна. Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийг 2016-2020, 2020-2025 он гэсэн хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан. Уг тогтоолын зорилт нь хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, хоол тэжээлээс хамааралтай өвчин эмгэгийг бууруулах болно. 5 хүртэлх насны хүүхдийн илүүдэл жинтэй хүүхдийн эзлэх 2013 оны суурь түвшин 16.7%, таргалалттай хүүхдийн эзлэх хувь 7.3% байсныг 2020 он гэхэд 16% болон 7%-иас бага болгоно. 12-17 насны өсвөр насны хүүхдийн илүүдэл жин, таргалалтын хувь 2013 оны суурь түвшин 11.2%-ийг 11%-иас бага болгох, 15-64 насны хүн амын илүүдэл жингийн тархалтыг 54.4%-ийг 53%-иас бага, таргалалтыг 19.7%-иас 18% руу оруулах гэсэн 2020 оны зорилтот түвшингүүдийг заасан. Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал судалгааг 5 жил тутам хийдэг бөгөөд хамгийн сүүлд 2017 онд хийсэн тул дээрх зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээг 2022 онд үнэлнэ.

1.2 Чихрийн шижингийн өвчлөл, шалтгаан

1.3 Шүдний өвчлөл

Хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор сүүлийн 10 жилийн дунджаар шүд цоорох өвчин 14.2%-ийг эзэлж, 2019 оны байдлаар 15.7% болсон нь сүүлийн 10 дунджаас 1.4 пунктээр өссөн байна. Шүд цоорох өвчнийг 10000 хүн амд ноогдох байдлаар 2019 оныг 10 жилийн дундажтай харьцуулбал улсын хэмжээнд 110-р өсчээ. ЭМЯ-ны “Эрүүл шүд–эрүүл хүүхэд” хөтөлбөрийн тайланд дурдсанаар улсын хэмжээнд 5-6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 94%, 12 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 84%-тай гэсэн нь чихрийн хэрэглээ их буйг харуулж байна. Түүнчлэн 5-6 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын суурь түвшин 86.1%-ийг 55%, 12 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалт 86.2%-ийг 50% болгон бууруулах зорилтыг дээрх хөтөлбөрийн хүрээнд 2023 он гэхэд хүргэнэ гэсэн байгаа.

1.4 Таргалалтын зардал

Таргалалт бол урьдчилан сэргийлэх боломжтой ч өвчилсөн тохиолдолд хугацаа шаардахын зэрэгцээ их хэмжээний зардалтай халдварт бус өвчин. Эдийн засгийн бодит салбарын хувьд бүтээмж буурах, өвчлөлөөс шалтгаалсан ажлын цагийн бууралт бий болгодог. Азийн хөгжлийн банкны хийсэн судалгаанд Ази Номхон далайн бүсийн 42 орон хамрагдсан ба таргалалттай холбоотойгоор эдийн засгийн бүтээмжийн алдагдлын зардал нь 35.8 сая доллар, эрүүл мэндийн салбарын зардлын 1.45% болдог гэжээ.

1.5 Чихэрлэг ундаанд татвар ногдуулах бодлого

Чихэрлэг ундааны хэрэглээ эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдгийг шинжлэх ухааны олон судалгаагаар нотолсон. Тодруулбал өдөрт авах шаардлагатай илчлэгийг нэмэгдүүлснээр биеийн жин нэмэгдэх, чихэрлэг ундааны хэрэглээ чихрийн шижин 2-ын шууд хамаарал зэргээр олон судалгааг дурдаж болно. ДЭМБ хүн өдөрт авах

шаардлагатай илчлэгийн 10%-иас бага хэмжээг чихрээс авах гэсэн нь 12 цайны халбага чихэртэй тэнцэнэ. 2015 зөвлөмжөөрөө чихрийн хэт хэрэглээ нь таргалалт, шүдний өвчлөлд нөлөөлөх ба хэрэглээг 5 цайны халбага болгон бууруулах зөвлөмж гаргасан.

Хоёр. Чихэрлэг ундаанд татвар ногдуулах үндэслэл

ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах зорилгоор чихэрлэг ундааны зах зээлийг судлан татварын боломжит хувилбар гаргах судалгааг ЭМЯ, АШУҮИС, НЭМХ болон бусад холбогдох газруудтай хамтарсан баг судалгаа хийсэн. Тус судалгааны зорилго нь чихэрлэг ундаанд татвар ногдуулсан улс орнуудын туршлага, татвар ногдуулснаар богино, урт хугацаанд гарах үр нөлөөг тооцох байлаа. Чихэрлэг ундаанд татвар ногдуулан илүүдэл жин, таргалалтыг бууруулах бодлогын арга хэмжээний талаар судалгаа нилээд хэвлэгджээ. Зүүн Ази, Номхон далайн бүсийн¹ 20 орон (22-33), Европын 7 улс² (34-39), Өмнөд Азийн нэг улс³ (40), Латин Америк, Карибын тэнгисын 5 улс, Англид хамаарах нэг нутаг дэвсгэр⁴ (41-45), Африкийн 2 улс⁵ (46, 47), Хойд Америкийн нэг улс (АНУ-ын олон муж) (48-53) чихэрлэг ундаанд татварын бодлого хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлэх шийдвэр гаргаад байна. Тиймээс бидний судалсан хэвлэлийн тоймд зөвхөн өндөр болон дунд орлоготой улсууд төдийгүй олон тооны бага-дунд болон бага орлоготой улсууд хамрагдсан. Чихэрлэг ундаанд татварыг улс орон бүр эдийн засгийн нөхцөл байдал, улс төрийн болон нийгмийн орчноос хамааран олон түвшинд, олон хувилбараар тогтоосон байлаа. Улс орнуудын чихэрлэг ундааны татварын бодлогын хэрэглээг дэлгэрэнгүй байдлаар бүс нутаг, орлогын түвшингээр хавсралтад харуулав. Зарим улс татварыг зөвхөн зөөлөн ундааг хамруулан тогтоосон байсан бол зарим нь нэмэгдэл сахартай бүх төрлийн ундаанд (амтлаг сүү, жимсний ундаа, амтлаг тараг гэх мэт) болон тэдгээрийг бэлтгэх түүхий эдэд (жишээлбэл, чихэрлэг ундаа найруулах нунтаг, сироп гэх мэт) ногдуулсан байна.

Татварын түвшин улс орон бүрт өөр байлаа. Жишээлбэл, АНУ-ын янз бүрийн мужид татварын хэмжээг 0-7%-иар тогтоосон байлаа. Онцгой татварын хэмжээ Барбадос, Камбож, Лаос, Соломоны арлууд, БНСУ-д 10%-иар тогтоосон бол хамгийн өндөр түвшинг Өмнөд Африкт (20%), Бангладеш (25%), Микронезийн холбооны улс (25%), Кирибати (40%) улсуудад тогтоожээ. Номхон далайн арлын орнуудад чихэрлэг ундаанд импортын татвар тогтоосон байв.

Тус судалгааны хүрээнд чихэрлэг ундаанд татвар ногдуулсан үр нөлөөг судалсан шинжлэх ухааны 22 өгүүллийг харьцуулсан ба бүхэлдээ чихэрлэг ундааны хэрэглээ буурч эрүүл мэндийн байдалд эерэг нөлөө үзүүлсэн байна. Судалгааны загвараар тооцсон эрэлтийн үнийн мэдрэмж ч сөрөг байсан нь дээрх өгүүлүүдтэй агуулга нэг буюу чихэрлэг ундаанд татвар ногдуулах нь хэрэглээ бууруулдаг зүй тогтлыг харуулсан байна. Жишээлбэл өндөр орлоготой орнуудын хувьд үнийн мэдрэмж -0.63-аас -1.3, дунд орлоготой улс орнуудад -0.72-с -1.3, бага орлоготой орны төлөөлөл Энэтхэгийн тохиолдолд -0.94 гарчээ. Өөрөөр хэлбэл татвар ногдуулснаар үнэ 1%-иар

¹ Америкийн Самоа, Австрали, Камбож, Күүкийн арлууд, Фижи, Францын Полинези, Кирибати, БНСУ, Лаос, Маршалын Арлууд, Микронезийн холбооны улс, Науру, Хойд Марианы Арлууд, Шинэ Каледон, Палау, Папуа Шинэ Гвиней, Самоа, Соломоны арлууд, Тонга, Вануату

² Дани, Финланд, Франц, Унгар, Ирланд, Норвеги, Англи

³ Бангладеш

⁴ Барбадос, Чили, Доминикан, Мексик, Сан Хелений арлууд

⁵ Өмнөд Африк, Маврикий


өсөхөд хэрэглээ 0.6-1.3%-иар буурч буйг харуулжээ. Түүнчлэн чихэрлэг ундааны хэрэглээ буурснаар Энэтхэгт илүүдэл жин, таргалалт 3%, чихрийн шижин 2-ын шинэ өвчлөл 1.6%-иар буурсан бол дунд орлоготой орны төлөөлөл Мексикт чихэрлэг ундаанд 10%ийн татвар ногдуулснаар илүүдэл жингийн тархалтыг 0.51%, таргалалтын тархалтыг 2.54%, чихрийн шижингийн шинэ тохиолдлыг 1.7%-6.8% бууруулах боломжтойг тооцсон байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд ч мөн адил чихэрлэг ундаанд татвар ногдуулснаар илүүдэл жин, таргалалт, чихрийн шижин, шүдний өвчлөл буурах тооцооллуудыг хийж тодорхой үр дүнд хүрч байна. Герман улсад чихэрлэг ундаанд 20%-ийн татвар ногдуулснаар илүүдэл жингийн тархалтыг 4%-иар (Schwendicke et al, 2017), Канад улсад илүүдэл жинг 69600 тохиолдлоор, таргалалтыг 400000 тохиолдлоор бууруулахыг судалж тогтоожээ (Jones et al, 2012). Эндээс улс орнууд хөгжлийн түвшин, орлогын ялгаатай байдлаас үл хамааран хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгын дор эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй аливаа бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах бодлого хэрэгжүүлдгийн амжилттай жишээ нь чихэрлэг ундаанд татвар ногдуулах гэдгийг харж болно.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Монгол улс дахь илүүдэл жин, таргалалтын тархалт

Хүн амын хоол тэжээлийн судалгааны үр дүнгээс харахад насны бүлгээс үл хамааран илүүдэл жин, таргалалт эрчимтэй нэмэгдсэн байна. 15-49 насны эмэгтэйчүүдийн илүүдэл жин, таргалалт энэ хугацаанд 2 дахин нэмэгдсэн бол 7-11 насны хүүхдийн илүүдэл жин ба таргалалт 7 дахин нэмэгдсэн байна. 5 жил тутам хийгддэг энэхүү судалгаа нь хүн амын хоол тэжээлийн шимт байдал, эрүүл хооллолт, хоол хүнсний хэрэглээнээс шалтгаалсан өвчлөл зэрэг цогц асуудлыг хамардаг.

Зураг 2. Монгол улс дахь илүүдэл жин, таргалалтын тархалт, насны бүлгээр



Эх сурвалж: Хүн амын хоол тэжээлийн үндэсний 4 ба 5-р судалгаа

2. Монгол улсын чихэрлэг ундааны зах зээлийн судалгаа

А. Дотоодын үйлдвэрлэл ба импортын чихэрлэг ундааны нийлүүлэлтийн хандлага

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол улсын чихэрлэг ундаа, усны зах зээлийн хэмжээ тасралтгүй өсч 370 сая литрт хүрсэн байна. Дотоодын үйлдвэрлэл 3 дахин нэмэгдэж нийт нийлүүлэлтийн 92%-ийг эзэлдэг болсон бол импортын хэмжээ харьцангуй тогтмол байна. Чихэрлэг ундаа үйлдвэрлэлийн нэртэй брэнд болох Кока Кола, Пепси Кола үйлдвэрүүд нээгдэхийн зэрэгцээ үндэсний үйлдвэрлэгчид болох АПУ

ХК, Витсамо ХХК, Монфреш ХХК хөрөнгө оруулалт хийн хүчин чадлаа нэмэгдүүлснээр дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ энэ хугацаанд 5%-иар нэмэгджээ. Энд анхаарах нэг зүйл бол импортын ундааны нэр төрлийг ус рашаан, ундаа жүүс гэж ангилан статистикийн мэдээлэл гаргадаг бол дотоодын үйлдвэрлэлийг хийжүүлсэн цэвэр ус, амтат ус ба ундаа, сироп, жүүс, энерги дринк гэж ангилан тоон мэдээллийг гаргадаг. Импортын мэдээнд буй ус, рашаан гэсэн зүйл импортын ундааны нийт биет хэмжээний 10%-иас бага, дотоодын үйлдвэрлэлийн мэдээлэлд буй хийжүүлсэн цэвэр ус, жүүс, жүүс цай гэсэн нэр төрөл тасралтгүй өсч иржээ.

Зураг 3. Монгол улсын ус, ундаа, жүүсний нийлүүлэлт (мян,л)




Эх сурвалж: ҮСГ, 2020

Бүтээгдэхүүн	2010	2015	2020
Ус рашаан	7,726,172,614	40,246,227,078	65,124,381,918
Ундаа, цай	54,993,843,840	179,186,624,360	451,076,569,104
Жимсний шүүс	66,151,454,432	119,691,915,429	131,850,154,752
Нийт дүн	128,871,470,886	339,124,766,866	648,051,105,774

Дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг ҮСГ-ын хэрэглээний үнийн индекс тооцоход ашиглаж буй 3 жишиг бүтээгдэхүүний үнээр тооцон, импортын мэдээний ундаа, жүүсний мэдээг жимсний шүүс гэсэн ангилалд оруулан нийт ус, ундаа, жүүсний сүүлийн 10 жилийн борлуулалтыг тооцов. 2010 онд 130 сая литр байсан нийт зах зээл 370 гаруй сая литр болж 2.7 дахин нэмэгджээ. Харин үнийн дүн 5.3 дахин нэмэгдсэн байгаа нь 10 жилийн хугацаанд нэгж бүтээгдэхүүний үнэ биет хэмжээнээс хурдацтай өссөн ба импортын бүтээгдэхүүний хувьд төгрөгийн ханшны уналт гол нөлөө үзүүлжээ.

Дотоодын үйлдвэрлэлийн 6 нэр төрлийн ундааны нэр төрлийн сүүлийн 10 жилийг авч үзвэл хийжүүлсэн ус, рашаан болон амтат ус, ундаа 3 дахин нэмэгдэж, сиропны үйлдвэрлэл 3 дахин буурчээ. Мөн хугацаанд үйлдвэрлэсэн жүүсний хэмжээ 10 орчим хувиар буурсан ч бусад төрлийн жүүсний үйлдвэрлэл эрчимтэй нэмэгдэж байна. Стандартчлал хэмжил зүйн газрын мэдээлэлд эдгээр бүтээгдэхүүний чихрийн орц

найрлагыг нарийвчлан зааж өгдөггүй тул бусад төрлийн жүүсний чихрийн орц найрлагатай холбоотой дүгнэлт өгөх боломжгүй байна. Бусад төрлийн чихрийн агуулга өндөртэй жүүсийг амтат ус, ундаатай адилтган үзэж чихрийн хэрэглээ бууруулах татварын тооцоололд оруулдаг.



Эх сурвалж: ҮСГ, 2020

Б. Дотоодын үйлдвэрлэлийн амтат ус, ундааны үнийн хандлага

ҮСГ-ын хэрэглээний үнийн индекс тооцоход сонгон авдаг үндсэн 3 бүтээгдэхүүний сүүлийн 10 жилийн үнийг хандлагыг доор харуулав. 2010 оныг суурь болгон авч үзвэл цэвэр усны үнэ 1.5 дахин, ундааны үнэ 2 дахин нэмэгдсэн бол жүүсний үнэ 50 хувиар нэмэгджээ.



Статистикийн газрын судалгаанд ашиглаж буй 3 үндсэн бүтээгдэхүүний үнийг ашиглан дотоодын үйлдвэрлэлийн ус, ундаа, жүүсний нийлүүлэлтийн дүнг тооцоход 586 тэрбум төгрөгний борлуулалт хийгддэг дүн гарч байна.

Борлуулалтын дүн		2010	2015	2020
Цэвэр ус (вопоциа 1.5 л үнээр)	төгрөг	6,693,766,333	38,777,184,000	62,519,543,918
Ундаа (Бидний ундаа 1.25 л үнээр)	төгрөг	54,993,843,840	152,571,975,360	407,681,188,464
Жимсний шүүс (Монфреш 1 л үнээр)	төгрөг	52,606,337,400	92,179,115,600	73,232,860,752
Жүүс цай (Монфреш 1 л үнээр)	төгрөг		26,614,649,000	43,395,380,640
Нийт дүн		114,293,947,573	310,142,923,960	586,828,973,774

В. Ус, ундааны импорт

2020 оны байдлаар ус, рашааны импортын хэмжээ 1.8 сая литр, ундаа, жүүсний импортын хэмжээ 26.3 сая литр байгаа нь 2010 онтой харьцуулахад ус рашааны импорт өсөлтгүй, харин ундаа, жүүсний импортын хэмжээ 2.3 дахин нэмэгдсэн байна. Нэг талаас дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, дэлхийн брэнд бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болсон нөгөө талаас валютын ханшнаас шалтгаалсан импортын бүтээгдэхүүний үнэ өссөнөөр ус ундааны зах зээлийн нийлүүлэлтэд эзлэх импортын хэмжээ тасралтгүй буурч байна.



Монгол банкны зарласан албан ханшны мэдээгээр 2010 оны 12-р сард 1 ам.доллар 1256.47 төгрөгтэй тэнцэж байсан бол 2020 оны 12-р сарын байдлаар 2849.55 төгрөг болж өөрчлөгджээ. Дээрх зурагт импортолж буй ус рашааны нэг литрийн үнэ 0.4-с 0.5 доллар, ундаа, жүүсний нэг литрийн үнэ 0.8 доллар орчим тогтвортой харагдаж байна. Үүнийг доллар төгрөгийн ханшаар хөрвүүлбэл 2010 онд импортын 1 литр ус, рашаан 536.64 төгрөг, импортын ундаа, жүүсний нэг литрийн үнэ 1006.95 төгрөг байсан бол 2020 оны 12 сарын ханшаар 1411.49 төгрөг болон 2254.4 төгрөг болж 2.2-2.6 дахин нэмэгдсэн байна. Хэдийгээр импортолж буй ус, ундааны үнэ ханшийн зөрүүгээр үнэтэй болсон ч импортлох хэмжээ буурахгүй байгаа нь үнийн мэдрэмжгүй хэрэглэж байна гэсэн үг биш. Нийт импортолж буй бүх бараа үйлчилгээний хувьд ханшийн уналтаар бий болсон үнийн өсөлтийг зах зээлд оруулж буй тул зах зээл түүнийг мэдрэмж багатай хүлээж авсан гэж дүгнэж болно.

	2010	2015	2020
Ус рашаан	1,032,406,281	1,469,043,078	2,604,838,000
Ундаа жүүс	13,545,117,032	27,512,799,829	58,617,294,000
Нийт импортын дүн	14,577,523,313	28,981,842,906	61,222,132,000

Ус, ундаа, жүүсний импортын хэмжээг гаальд мэдүүлсэн үнийн дундаж үнээр тооцвол импортолж буй ус рашааны төгрөгөөр илэрхийлэгдэх дүн 2 дахин, ундаа жүүсний үнийн дүн 4.5 дахин нэмэгдсэн байна. Дээр дурдсанчлан ундаа, жүүсний биет хэмжээ 2 дахин нэмэгдсэн ч үнийн дүн түүнээс 2 дахин нэмэгдсэн харагдаж буй нь нэг талаас төгрөгний ханшийн уналт, нөгөө талаас дотоодод үйлдвэрлэгддэггүй нэр төрлийн бүтээгдэхүүн импортолж буйтай холбоотой.

Г. Ус, ундааны дотоодын зах зээлийн хэрэглээний хандлага

Нэг өрхийн ус ундаанд зарцуулж буй сарын дундаж зардал (төгрөгөөр)



Эх сурвалж: ҮСГ, Өрхийн мөнгөн орлого зарлагын судалгаа, 2010-2020

2020 оны 12 сарын байдлаар өрхийн сарын мөнгөн зарлагын 3.9 хувийг эзэлж буй цэвэр ус, ундаа, жимсний шүүсний хэрэглээний зардал тасралтгүй өсч ирсэн. 2010 онд 3419 төгрөг байсан бол 2020 онд 12102 төгрөг болж 4 дахин нэмэгдсэн ба үүний 95%-ийг ундаа, жимсний шүүсний хэрэглээ эзэлж байна. Зургаас харахад хийжүүлсэн болон хийжүүлээгүй ундааны зардал 4.6 дахин, жимс, ногооны өтгөрүүлсэн шүүсний хэрэглээний зардал 2.3 дахин нэмэгджээ. Ундаанд зарцуулах өрхийн хэрэглээний зардлын өсөлт дотоодын үйлдвэрийн ундааны болон импортын ундааны үнийн өсөлтөөс илүү байгаа нь бодит хэрэглээ нэмэгдэж байгааг харуулж байна..

Д. Сахар, чихрийн зүйлийн хэрэглээ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2-р сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар жишсэн нэг хүний сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь хоногт 33 гр (128 ккал) буюу жилийн 12 кг байна гэж баталсан.

2020 оны байдлаар нийт хүн амын сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь 31.7 мянган тонн байсан бол нийт үйлдвэрлэл⁶ нь 192.6 мянган тонн байна. Нийт үйлдвэрлэлийг хэрэгцээнд харьцуулан хангамжийн түвшинг тооцоход сахар чихрийн зүйлийн хангамж 6 дахин их байна.

Зураг 1. Сахар, чихрийн зүйлийн хэрэглээ, хэрэгцээ, хангамжийн түвшин

⁶ Энд сахар, чихрийн зүйлийн хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг энэ бүлэгт шилжүүлж тооцсон (ёотон-1.0, хатуу чихэр-0.96, шоколад, зөөлөн чихэр, зефир-0.46, жимсний чанамал, сироп-0.46, хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа-0.47).



Сахар, чихрийн зүйлийн бүлгийн хэрэглээг задлан харахад хийжүүлсэн болон хийжүүлээгүй ундаа 65.5 хувийг, сахар, ётон 29.3 хувийг, хатуу чихэр 2.5 хувийг бусад чихрийн бүтээгдэхүүн 2.7 хувийг эзлэж байна.

Зураг 2. САХАР, ЧИХРИЙН ЗҮЙЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ, мянган тонн, сахар чихрийн зүйлд шилжүүлснээр, 2020 он



Е. Чихэрлэг ундааны хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааны үр дүн

Бид чихэрлэг ундааны хэрэглээнд нөлөөлөх нийгэм-эдийн засгийн нөлөөллийг судлах зорилгоор энэ төрлийн ундаанд өрхийн зарцуулсан зардалд цензурлэсэн регрессийн загвар (Tobit)-ыг ашиглан анализ хийсэн. 2015 оны ӨНЭЗТС-д өрхийн тэргүүний боловсролын түвшинг бүртгээгүй байсан тул бид 2014 оны судалгаанд дүн шинжилгээ хийсэн. Чихэрлэг ундааны хэрэглээнд статистикийн ач холбогдолтойгоор нөлөөлж буй гол хүчин зүйлд өрхийн амьдарч буй байршил орж байсан бөгөөд нийслэл хотод амьдарч байгаа өрхийн чихэрлэг ундааны хэрэглээ илүү өндөр байв. Мөн өрхийн тэргүүний боловсролын түвшин хэрэглээнд нөлөөлж байсан бөгөөд, чихэрлэг ундааны хэрэглээтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн сөрөг үр дагаварын талаарх мэдлэг өндөр боловсролтой бүлэгт ч бага байгаа нь тодорхойлогдсон. Мөн түүнчлэн өрхийн сарын дундаж орлого чихэрлэг ундааны хэрэглээтэй эерэг хамааралтай байв. Өөрөөр хэлбэл, өрхийн сарын орлого ихсэх тусам чихэрлэг ундааны хэрэглээ нэмэгдэж байлаа.

Хүснэгт 1 Тобит регрессийн үр дүн, ӨНЭЗТС 2014

Хувьсуур	Коэффициент (Стандарт алдаа)
Нэг хүнд ногдох Чихэрлэг ундааны зарцуулалт	
Log (Өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого)	1666.971*** (83.141)
Өрхөд байх хүүхдийн харьцаа	-5.525 (332.596)
Өрхийн тэргүүний нас	-50.193*** (6.001)
Улаанбаатар, Аймгийн төв	-127.802 (149.824)
Сумын төв	-908.442*** (175.575)
Хөдөө	-2649.788*** (367.669)
Өрхийн тэргүүн бага боловсролтой байх	1611.531*** (490.689)
Өрхийн тэргүүн дунд боловсролтой байх	1363.715*** (490.689)
Өрхийн тэргүүн дээд боловсролтой байх	1969.427*** (495.430)
Интерцепт	-18190.282*** (1193.788)
N	9077
Log-likelihood	-58081.708
$\chi^2_{(9)}$	970.997

Ач холбогдлын түвшин: †:10% *: 5% **: 1%

Ё. Улаанбаатар хотын хүүхэд, өсвөр үеийн чихэрлэг ундааны хэрэглээний судалгааны үр дүн

Улаанбаатар хотын 2-18 настай хүүхэд, өсвөр үеийг хамруулан 2015, 2017 онд хийгдсэн (71) нэгэн судалгааны үр дүнг энд толилуулж байна. Судалгаанд нийгэм, эдийн засгийн мэдээлэл, хүүхдүүдийн өндөр, биеийн жин, амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөний идэвхтэй болон идэвхгүй байдал зэрэг мэдээллийг шингэний хэрэглээний 24 цагийн эргэн санах асуумжтай хослуулан цуглуулсан байна. Энэхүү судалгааны дескриптив үр дүнг бид тайландаа ашигласан ба судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн гуравны нэг нь чихэрлэг ундааг сүүлийн 24 цагийн хугацаанд уусан байлаа. Хоногт хэрэглэсэн чихэрлэг ундааны хэмжээ судалгаанд хамрагдсан 2-3 настай хүүхдүүдэд 326 мл, 4-8 настай хүүхдүүдэд 414 мл, 9-13 настай хүүхдүүдэд 428 мл, 14-18 настай хүүхдүүдэд 425 мл байлаа. Хүүхэд, өсвөр үеийн чихэрлэг ундааны хэрэглээ хоногт 1 лааз (330 мл) буюу түүнээс их байгаа нь бидний анхаарлыг татаж байгаа юм. Цаашилбал, судалгааны хүн амд чихэрлэг ундаа хоногийн нийт шингэний хэрэглээний 11.0%-16.4% -ийг эзэлж байгаа нь тодорхойлогдсон байна.

Хүснэгт 2. Улаанбаатар хотын хүүхэд, өсвөр үеийн чихэрлэг ундааны хэрэглээ, 24 цагийн эргэн санах судалгаа

Ус, хэрэглэсэн хэмжээ (мл-ээр)	ундааны ангилал,	2-3 настай (N=350)	4-8 настай (N=724)	9-13 настай (N=510)	14-18 настай (N=468)
Ус	Хэрэглэсэн	52.9%	60.4%	71.4%	84.0%
	Дундаж (С.Х)	269 (234)	440 (316)	493 (309)	797 (559)
Цай	Хэрэглэсэн	82.3%	93.9%	92.9%	57.1%
	Дундаж (С.Х)	546 (257)	710 (360)	759 (395)	680 (406)
Сүү	Хэрэглэсэн	67.1%	25.7%	8.2%	6.8%
	Дундаж (С.Х)	267 (112)	260 (156)	255 (128)	225 (120)

Чихэрлэг ундаа	Хэрэглэсэн	46.3%	30.9%	31.2%	43.8%
	Дундаж (С.Х)	326 (174)	414 (252)	428 (250)	353 (267)
Кофе	Хэрэглэсэн	0	2.1%	3.7%	4.7%
	Дундаж (С.Х)	0	393 (244)	342 (227)	214 (23)

Энэхүү микро түвшний судалгаа чихэрлэг ундааны хэрэглээ хүн амын дунд, ялангуяа хүүхэд, залуу үеийн дунд түгээмэл болж, ямар ихээр тархсан болохыг тодорхой илэрхийлж байна. Чихэрлэг ундааны хэрэглээний сөрөг үр дагаврын талаарх хүн амын мэдлэг, хандлагыг өөрчлөх нь ирээдүйд үүсэх илүүдэл жин, таргалалттай холбоотой архаг өвчнөөс сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болоод байна.

1. Чихэрлэг ундааны үнийн мэдрэмжийн тооцоолол

ДЭМБ-ийн зөвлөмж болон хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор чихэрлэг ундаанд татвар ногдуулсан улс орнуудын туршлагад үндэслэн үнийн мэдрэмжийн тооцоог хийсэн байна. Үнийн мэдрэмж нь үнийг 1 хувиар өөрчлөхөд хэрэглээ хэдэн хувиар ихсэх, багасахыг тодорхойлох ба чихэрлэг ундааны хувь урвуу хамааралтай байдаг нь эх сурвалжид авсан бүтээлүүдээр нотлогдсон. НЭМХ-ийн судалгаанд зөвхөн нэг бүтээгдэхүүний хэрэглээ үнийн хамаарлаас гадна тухайн бүтээгдэхүүний үнийн өсөлт орлуулах бүтээгдэхүүнд хэрхэн нөлөөлөх солбицох мэдрэмжийг тооцжээ. Тооцооллын үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Солбицох үнийн мэдрэмж, Улаанбаатар хот, ӨНЭЗТС 2015

	Сүү	Цай, кофе	Ус	Чихэрлэг ундаа	Хөнгөн зууш	Сахар	Дессерт	Архи
Сүү	-.923	-.172	.018	-.086	.131	-.028	-.090	.082
Цай, кофе	-.609	.020	.002	-.094	.146	.093	-.207	.049
Ус	1.087	-.022	-	-.491	-.209	.529	-.346	-.451
Чихэрлэг ундаа	-.362	-.122	-.029	-.681	.283	-.012	.002	-.189
Хөнгөн зууш	.283	.023	-	.130	-1.076	.027	-.055	-.168
Сахар	.015	.158	.066	.035	.239	-.931	.224	-.314
Дессерт	-.501	-.259	-	-.014	-.293	.095	-.362	.079
Архи	.949	.052	-	-1.318	-3.347	-1.071	.212	1.336

Хүснэгт 4. Солбицох үнийн мэдрэмж, Улаанбаатараас бусад газарт, ӨНЭЗТС 2015

	Сүү	Цай, кофе	Ус	Чихэрлэг ундаа	Хөнгөн зууш	Сахар	Дессерт	Архи
Сүү	-.963	-.100	.015	-.058	.098	-.018	-.065	.081
Цай, кофе	-.493	.140	-.004	-.149	.158	.103	-.232	.015
Ус	3.594	-.225	-	-1.615	-.640	1.690	-1.134	-

Чихэрлэг ундаа	-531	-186	-041	-568	.405	-017	-013	-284
Хөнгөн зууш	.381	.034	-006	.214	-1.112	.048	-.136	-.335
Сахар	.102	.128	.065	.031	.220	-.935	.242	-.313
Дессерт	-.382	-.182	-.018	-.003	-.228	.075	-.501	.074
Архи	.627	-.046	-.076	-.583	-1.499	-.480	.133	.036

Судалгааны багийн тооцоогоор чихэрлэг ундааны үнэ 10%-иар нэмэгдэхэд хэрэглээ Улаанбаатар хотод 6.8%, бусад газар 5.7%-иар буурах үр дүн гарсан. Энэ нь чихэрлэг ундаанд татвар ногдуулснаар үнэ өсч, хэрэглээ буурах бусад улс орны бодлогын үр дүнтэй ижил үр дүн харуулсан. Түүнчлэн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй буюу ДЭМБ-ын зөвлөмжид дурдсан ундааны чихрийн хэмжээнээс илүү чихрийн орцтой ундаанд татвар ногдуулснаар орлуулах ундаануудын хэрэглээ рүү шилжих, үйлдвэрлэгчид орц найрлагадаа өөрчлөлт оруулах үр дагавар гарна.

Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал.

Ундааны найрлага дахь чихрийн орцоос хамаарсан татвар тогтоох нь хууль санаачлах тэргүүн зорилго болох хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилготой шууд уялдана. Тодруулбал ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу 100 мл ундаанд 5 граммаас бага чихрийн орцтой бол 0 татвар, түүнээс дээш чихрийн орцтой бол 20 хувийн татвар ноогдуулах нь татварын орлого нэмэгдүүлэхээс илүү эрүүл мэндийн зорилгод бүрэн нийцнэ.

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ноогдуулах онцгой албан татварын хэмжээ	
			2022 оноос хойш	
10	Чихрийн агууламж орсон амтат ус, ундаа	100мл	100мл-т агуулагдах чихэр 0-5гр	0 төгрөг
			100мл-т агуулагдах чихэр 5гр-с дээш	500 төгрөг

НЭМХ-ийн судалгааны баг ДЭМБ-ын ТаХSim загварыг ашиглан ундааны жижиглэнгийн үнэд 10%, 20%, 30%-иар онцгой татвар ногдуулахад гарах нөлөөг тооцсон байна. Тооцооллын 2016 оны суурь үзүүлэлтүүд дээр тулгуурлан хийсэн ба 20%-иар үнийн дүнд онцгой албан татвар ногдуулбал 98.3 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт орох, 10%-иар татвар ногдуулбал 48.7 тэрбум төгрөгний орлого татварт нэмэгдэж орох боломжтойг тооцоолжээ. Түүнчлэн 10%-иар татвар ногдуулбал нэг хүний жилийн ундааны хэрэглээ 10.2 литрээр, 20%-иар татвар ногдуулбал 22.8 литрээр хэрэглээ буурна гэж тооцжээ.

Статистик мэдээлэлд дотоодын болон импортын ундаа, амтат ус, зарим төрлийн цайны үнэ болоод тоо хэмжээг нарийвчлан гаргадаггүй нь тооцоолол хийхэд хүндрэлтэй байлаа. Боломжит мэдээлэлд тулгуурлан ундаа, ус, жүүсний зах зээлийн нийт борлуулалтыг дараах байдлаар тооцсон. Импортын мэдээлэлд дурдагдсан ундаа, жүүс гэсэн ангилалтай мэдээллийг жимсний шүүс гэсэн ангилалд шилжүүлэн тооцсон тул татвар ногдох тоо хэмжээнд оруулаагүй. Бүтээгдэхүүний нэр төрөл нарийвчлан гарсан тохиолдолд татвар ногдох бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх эерэг нөлөөтэй болно.

Ингэснээр чихэр агуулсан буюу татвар ногдуулах бүтээгдэхүүнд бүх төрлийн ундаа, амтат усыг багтаасан. Энэ нь 451 тэрбум төгрөгний борлуулалттай бөгөөд 20 хувийн татвар ногдуулахад улсын төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нь 90.2 тэрбум төгрөг болно. Энэхүү тооцоолол нь ДЭМБ-ийн санхүүжилтээр ЭМЯ, ЭМШУИС, НЭМХ-ийн татварын тооцоололд дурдагдсан төсөвт орох боломжтой дүн болох 98.2 тэрбум төгрөгийн дүнтэй ойролцоо гарчээ.

Бүтээгдэхүүн	2010	2015	2020
Ус рашаан	7,726,172,614	40,246,227,078	65,124,381,918
Ундаа, цай	54,993,843,840	179,186,624,360	451,076,569,104
Жимсний шүүс	66,151,454,432	119,691,915,429	131,850,154,752
Нийт дүн	128,871,470,886	339,124,766,866	648,051,105,774

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хүн амын дундах халдварт бус өвчлөлийг бууруулах нэг гол хүчин зүйл нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хоол хүнсний хэрэглээг бууруулах юм. ДЭМБ-ийн зөвлөмж болон чихэрлэг ундааны хэрэглээг бууруулахын тулд татварын бодлого хэрэгжүүлсэн олон улсын туршлагад тулгуурлан татвар ногдуулахыг судаллаа. Илүүдэл жин, таргалалт, чихрийн шижин-2, шүдний өвчлөлийн шууд шалтгааны нэг чихэрлэг ундааны хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй арга бол татвар ногдуулах юм. Одоогоор Монгол улсад мөрдөгдөж буй хүчин төгөлдөр стандартад ундааны чихрийн агууламжийг заасан лавламж, хэмжээ байхгүй байна. Түүнчлэн импортолж буй амтат ус, ундаанд ч чихрийн агууламжийг заасан стандарт байхгүй байгаа нь татварын үр нөлөөг үр дүнтэй болгоход хүндрэл учруулна. Гэсэн хэдий ч чихэрлэг ундаанд татвар ногдуулах асуудлыг хойшлуулах нь түүнээс шалтгаалсан дээрх өвчлөлүүдийг улам нэмэгдүүлэх, урт хугацаанд эрүүл мэндийн салбарт зардлын дарамт учруулах байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Үйлдвэрлэл, импортод нарийвчлан заасан стандарт байхгүй байгаа ч татвар ногдуулах хуулийг хугацаа алдалгүй хэлэлцэн баталж мөрдөх хугацаанд дээрх бэлтгэл ажлуудыг хийх хэрэгтэй гэж үзлээ.

Статистикийн газраас гаргаж буй амтат ус ундаа, чихрийн агууламжтай цай болон импортолж буй ундааны нийт дүн 270.7 сая литр ундааг 1000 төгрөгөөр тооцвол 270 гаруй тэрбум төгрөгийн борлуулалт болно. Өнөөдрийн байдлаар 100 мл ундаанд 5 грамм болон түүнээс доош чихрийн агууламжтай амтат ус, ундаа байхгүй байгаа тул нийт дүнд 20%-ийн онцгой албан татвар ногдуулбал улсын төсөвт 54 тэрбум төгрөгийн орлого төвлөрнө. Үүнээс илүү чухал үр дүн бол эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй чихэрлэг ундааны хэрэглээ дээр дурдсанчлан 13.4%-иар буурна. Чихэрлэг ундааны 92%-ийг дотоодын үйлдвэрлэгчид нийлүүлдэг тул ДЭМБ-ийн зөвлөмж болон татварын нөлөөгөөр ундаан дахь чихрийн агууламжийг 100 мл-т 5 грамм болон түүнээс бага чихрийн орцтой болгох өөрчлөлт хийхийн зэрэгцээ маркетинг, сурталчилгааны ажлуудаар дамжуулан эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бодит салбарын үйлдвэрлэлд ундаанд ногдуулах онцгой татвар сөрөг нөлөөгүй болно.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнсний аюулгүй байдлыг хангах нь засгийн газрын тэргүүлэх зорилго. Алсын хараа 2050, Тогтвортой хөгжлийн зорилтууд, 2020-2024 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөө болон бусад баримт бичигт хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, хүн амын эрүүл аж төрөх байдлыг хангах, хүүхдийн өвчлөлийг бууруулах гэсэн олон зорилгын хүрээнд чихрийн агууламжаас хамааруулан онцгой албан татвар ногдуулах нь үр дүнд хүргэнэ.

Олон улсын туршлагаас үзэхэд дээрх бодлогын арга хэмжээг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сурталчилгаа таниулга, цэцэрлэг сургуулийн орчинд борлуулалтын цэгийг хязгаарлах, чихэрлэг ундааны сурталчилгааг хязгаарлах, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний мэдээллийг олон нийтэд хүргэх, чихэрлэг ундааны шошгожилтод өөрчлөлт оруулах зэрэг бусад аргуудтай хавсруулах нь үр нөлөөг дээшлүүлнэ.

Цаашилбал чихрийн агууламж өндөртэй бусад бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах арга хэмжээг үе шатчилан хэрэгжүүлэх нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урт хугацаанд бий болох өвчлөл, түүнээс эрүүл мэндэд учрах зардлын дарамтыг багасгана.

Мөн оролцогч талуудтай хамтран уг татварын үр нөлөөг тодорхой дамтамжтай хэлэлцэн, үр нөлөөг үнэлэх шаардлагатай.

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

2021

ГАРЧИГ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ
ГУРАВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

ДӨРӨВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ
ЗАРДЛЫН ТАЛААР

ТАВ.ДҮГНЭЛТ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй хэмээн тунхагласан.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2016 онд бүх улс оронд хандан, таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд хамгийн багадаа 20 хувийн татвар ноогдуулахыг уриалсан. Илүүдэл жин, таргалалтанд хүргэдэг олон хүчин зүйлийн нэг нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, тэр дундаа чихэрлэг хүнс, ундааны хэрэглээ юм. Сургуулийн орчинд зарагдаж буй шингэний дийлэнх нь чихэртэй, хийжүүлсэн ундаа, шүүс мөн чихэр, жигнэмэг, шоколад байдгийг бид мэднэ. Судалгаанд хамруулсан сурагчдын хувьд ялангуяа тарган, илүүдэл жинтэй хүүхдүүдийн ууж буй шингэний дийлэнх нь амтат ундаа, мөн чихэр, жигнэмэгийн хэрэглээ хэвийн жинтэй хүүхэдтэй харьцуулахад 2-5 дахин их байсан.

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нарын судалгаанаас харвал 14-18 насныхны 54.9 хувь нь сургуулийн орчмоос чихэртэй ундаа худалдаж авдаг гэж хариулжээ.

Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтоолын хавсралтын 1.1., Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг 2025 он гэхэд 25 хувь, архины хортой хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг 10 хувь, давс, тамхины хэрэглээг 30 хувь, цусны даралт ихсэлтийг 25 хувь, таргалалт, чихрийн шижингийн өсөлтийг тогтоон барих”-аар, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2.2-ын 3 дахь зорилтод “2016-2020 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүнд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4 хувь, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хувь хүртэл бууруулах”-аар дэвшүүлсэн. Тэгвэл дээрх зорилтуудыг хэрэгжүүлж, ард иргэд, хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалахад амтат ус ундааны татварыг нэмэгдүүлэх нь хамгийн зардал багатай, үр дүнтэй арга юм. Амтат ундаанд 20 хувийн онцгой татвар ногдуулсны үр дүнд жилд нэг хүнд ногдох амтлаг ундааны хэрэглээг 22.8 литрээр бууруулах боломжтой тооцоолол гарч байна. Онцгой албан татвар ногдуулахын цаад мөн чанар нь татварын орлогыг нэмэгдүүлэх, эрүүл хэрэглээг хэвшүүлэх, зүрх судасны өвчин болон таргалалт, чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх, мөн дээрх өвчнөөс шалтгаалсан эрүүл мэндийн салбарт ирж буй ачааллыг бууруулах чухал зорилгуудыг агуулж байна.

ХОЁР.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал байхгүй бөгөөд эсрэгээрээ иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад дөхөм болох үндэслэлтэй.

Манай улсад 2012-2017 оны хооронд амтат ус, ундааны үйлдвэрлэл 30 хувиар, жимсний шүүстэй харьцуулахад хийжүүлсэн ундааны үйлдвэрлэл эрс

ессөн. Мөн Монгол Улсын 2012 оны өрхийн чихэрлэг ундааны зардлыг 2015 оныхтой хурьцуулахад 41 хувиар өссөн нь ноцтой үзүүлэлт юм. 2020 оны байдлаар нийт хүн амын сахар, чихрийн зүйлийн хэрэгцээ нь 31.7 мянган тонн байсан бол нийт үйлдвэрлэл /сахар, чихрийн зүйлийн хүнсний нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг энэ бүлэгт шилжүүлж тооцсон (ёотон-1.0, хатуу чихэр-0.96, шоколад, зөөлөн чихэр, зефир-0.46, жимсний чанамал, сироп-0.46, хийжүүлсэн, хийжүүлээгүй ундаа-0.47)/ нь 192.6 мянган тонн байна. Нийт үйлдвэрлэлийг хэрэгцээнд харьцуулан хангамжийн түвшинг тооцоход сахар чихрийн зүйлийн хангамж 6 дахин их байна. Энэ нь хэрэглэгчийн эрүүл мэнд ноцтой үр дагаварт хүрэхийг сэрэмжлүүлж байгаа баримт. Өвчилсөн үеийн оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээх зардал нь асар их бөгөөд харин сэргийлэх, хамгаалах, хянахад чиглэсэн бодлогын зөв, мөн цаг үеэ олсон шийдэл, шийдвэр нь зардал бага ч үр дүн нь илүү их байдаг.

ГУРАВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Богино хугацаанд үйлдвэрлэж, импортолж буй чихэрлэг ундаанд татвар ногдуулах нь борлуулалт буурах нөлөөтэй боловч эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бусад ундааны борлуулалт нэмэгдэнэ. Урт хугацаанд чихэрлэг ундааны жор найрлагад өөрчлөлт оруулснаар эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний оронд бусад орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортын хэмжээ нэмэгдэнэ. Энэ нь бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагын нэгэн бодит алхам болно.

ДӨРӨВ.ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Улсын төсөвт үүсэх ямар нэгэн зардал байхгүй. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүргийн дагуу эрүүл мэндэд эрсдэл учруулагч хүнсний бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах ёстой. Үүнийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга нь татвар бөгөөд богино хугацаанд төсвийн орлого нэмэгдэнэ. Тогтвортой хөгжлийн (зорилт 1), Ядуурлыг бууруулах (зорилт 3), Эрүүл мэндийг дэмжих (зорилт 12), Хариуцлагатай хэрэглээг дэмжих (зорилт 17), Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд чихэрлэг ундааны татварын бодлого бүрэн нийцнэ. Урт хугацаанд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний хэрэглээг бууруулснаар хүн амын эрүүл мэнд сайжрах ба эрүүл мэндийн салбарт энэ төрлийн өвчлөлийг учруулдаг зардлын дарамт буурна. Татвараас бүрдсэн орлогын тодорхой хэсгийг эрүүл амьдралын хэв маягийг сурталчлах, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнийг таниулах, хэрэглээнээс үүдсэн өвчлөлтэй тэмцэх ажилд зарцуулна. Чихэрлэг ундааны татварын сайн үр нөлөөнд тулгуурлан эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бусад бүтээгдэхүүний хэрэглээг ч өөрчлөх дараагийн бодлогыг хэрэгжүүлэх боломжтой болно.

ТАВ.ДҮГНЭЛТ

Хүн амын дундах халдварт бус өвчлөлийг бууруулах нэг гол хүчин зүйл нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хоол хүнсний хэрэглээг бууруулах юм. ДЭМБ-ийн зөвлөмж болон чихэрлэг ундааны хэрэглээг бууруулахын тулд татварын бодлого хэрэгжүүлсэн олон улсын туршлагад тулгуурлан татвар ногдуулахыг судаллаа. Илүүдэл жин, таргалалт, чихрийн шижин-2, шүдний өвчлөлийн шууд шалтгааны нэг чихэрлэг ундааны хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй арга бол татвар ногдуулах юм. Одоогоор Монгол улсад мөрдөгдөж буй хүчин төгөлдөр стандартад ундааны чихрийн агууламжийг заасан лавламж, хэмжээ байхгүй байна. Түүнчлэн импортолж буй амтат ус, ундаанд ч чихрийн агууламжийг заасан стандарт байхгүй байгаа нь татварын үр нөлөөг үр дүнтэй болгоход хүндрэл учруулна. Гэсэн хэдий ч чихэрлэг ундаанд татвар ногдуулах асуудлыг хойшлуулах нь түүнээс шалтгаалсан дээрх өвчлөлүүдийг улам нэмэгдүүлэх, урт хугацаанд эрүүл мэндийн салбарт зардлын дарамт учруулах байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Үйлдвэрлэл, импортод нарийвчлан заасан стандарт байхгүй байгаа ч татвар ногдуулах хуулийг хугацаа алдалгүй хэлэлцэн баталж мөрдөх хугацаанд дээрх бэлтгэл ажлуудыг хийх хэрэгтэй гэж үзлээ.

Статистикийн газраас гаргаж буй амтат ус ундаа, чихрийн агууламжтай цай болон импортолж буй ундааны нийт дүн 270.7 сая литр ундааг 1000 төгрөгөөр тооцвол 270 гаруй тэрбум төгрөгийн борлуулалт болно. Өнөөдрийн байдлаар 100 мл ундаанд 5 грамм болон түүнээс доош чихрийн агууламжтай амтат ус, ундаа байхгүй байгаа тул нийт дүнд 20%-ийн онцгой албан татвар ногдуулбал улсын төсөвт 54 тэрбум төгрөгийн орлого төвлөрнө. Үүнээс илүү чухал үр дүн бол эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй чихэрлэг ундааны хэрэглээ дээр дурдсанчлан 13.4%-иар буурна. Чихэрлэг ундааны 92%-ийг дотоодын үйлдвэрлэгчид нийлүүлдэг тул ДЭМБ-ийн зөвлөмж болон татварын нөлөөгөөр ундаан дахь чихрийн агууламжийг 100 мл-т 5 грамм болон түүнээс бага чихрийн орцтой болгох өөрчлөлт хийхийн зэрэгцээ маркетинг, сурталчилгааны ажлуудаар дамжуулан эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн бодит салбарын үйлдвэрлэлд ундаанд ногдуулах онцгой татвар сөрөг нөлөөгүй болно.